МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН 2021 ОНЫ ХАВРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАНЫ 3 ДУГААР САРЫН 25-НЫ ӨДӨР /ПҮРЭВ ГАРАГ/-ИЙН НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН ТОВЬЁГ

№	Баримтын агуулга	Хуудасны дугаар
1.	Хуралдааны товч тэмдэглэл:	1-18
2.	Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:	19-121
	1.Хүний эрхийн хамгаалагчийн эрх зүйн байдлын тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Улсын Их Хурлын гишүүн Д.Цогтбаатар 2020.05.07-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/	20-47
	2.Хууль зүйн туслалцааны тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2021.03.19-ний өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/	47-66
	3.Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн гишүүнээр томилох, чөлөөлөх тухай	66-95
	4.Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2021.03.19-ний өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/	95-111
	5.“Түр хороо байгуулах тухай” тухай Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Улсын Их Хурлын гишүүн Ц.Даваасүрэн нарын 22 гишүүнээс 2021.03.23-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/	111-119
	6.Дэлхийн шуудан холбооны дүрмийн 10 дугаар нэмэлт протоколыг соёрхон батлах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2021.03.19-ний өдөр өргөн мэдүүлсэн, соёрхон батлах/	119-121

Монгол Улсын Их Хурлын 2021 оны хаврын ээлжит чуулганы 3 дугаар сарын 25-ны өдөр /Пүрэв гараг/-ийн нэгдсэн хуралдааны товч тэмдэглэл

Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар ирц, хэлэлцэх асуудлын дараалыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлын нөхцөл байдалтай холбогдуулан Засгийн газраас Гамшгаас хамгаалах тухай хуулийн дагуу өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн тул Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 6 дугаар зүйлд зааснаар Улсын Их Хурлын чуулганы хуралдааныг цахим хэлбэрт шилжүүлж, Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар, Улсын Их Хурлын дэд дарга Т.Аюурсайхан, С.Одонтуяа, Улсын Их Хурлын гишүүн, Улсын Их Хурал дахь Монгол Ардын намын бүлгийн дарга Д.Тогтохсүрэн, Улсын Их Хурлын гишүүн, Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлгийн дарга Д.Ганбат, Нийгмийн бодлогын байнгын хорооны дарга М.Оюунчимэг, Хууль зүйн байнгын хорооны дарга С.Бямбацогт, Ёс зүй, сахилга хариуцлагын байнгын хорооны дарга Б.Бат-Эрдэнэ, Эдийн засгийн байнгын хорооны дарга Ж.Ганбаатар, Улсын Их Хурлын гишүүн Ш.Адьшаа, Н.Алтанхуяг, Г.Амартүвшин, Ё.Баатарбилэг, Ж.Батсуурь, Б.Баярсайхан, Б.Бейсен, С.Ганбаатар, Н.Ганибал, Х.Ганхуяг, Ц.Даваасүрэн, Г.Дамдинням, Т.Доржханд, Ц.Мөнхцэцэг, Х.Нямбаатар, Б.Пүрэвдорж, Ц.Туваан, Г.Тэмүүлэн, Д.Цогтбаатар, О.Цогтгэрэл, Ц.Цэрэнпунцаг, Л.Энх-Амгалан, Б.Энх-Амгалан нар "Их хуралдай" танхимаас, бусад гишүүд MyParliament программ болон цахим хуралдааны программыг ашиглан чуулганы нэгдсэн хуралдаанд цахимаар оролцов.

Хуралдаанд ирвэл зохих 75 гишүүнээс 43 гишүүн цахим хуралдааны программын ирцэд бүртгүүлж, 57.3 хувийн ирцтэйгээр хуралдаан 10 цаг 04 минутад Төрийн ордны "Их хуралдай" танхимд эхлэв.

Чөлөөтэй: Г.Ганболд;
Эмнэлгийн чөлөөтэй: Х.Болорчулуун, Н.Учрал;
Тасалсан: Д.Бат-Эрдэнэ, Ш.Раднаасэд, Ж.Эрдэнэбат;
Хоцорсон: Т.Аубакир -30 минут, С.Одонтуяа -2 цаг 10 минут, Ч.Хүрэлбаатар -40 минут, Б.Энх-Амгалан -40 минут.

Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4-т заасны дагуу Улсын Их Хурлын гишүүн Н.Алтанхуягаас ирүүлсэн албан бичгийг танилцуулж, Улсын Их Хурлын гишүүн Н.Алтанхуяг асуудал нэмэх горимын санал хэлэв.

Нэг.Хүний эрх хамгаалагчийн эрх зүйн байдлын тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд */Улсын Их Хурлын гишүүн Д.Цогтбаатар 2020.05.07-ны өдөр өргөн мэдүүлсэн,* ***анхны хэлэлцүүлэг****/*

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Хүний эрхийн Үндэсний Комиссын гишүүн бөгөөд даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ж.Хунан, мөн Комиссын гишүүн Б.Энхболд нар "Их хуралдай" танхимаас оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын дарга Э.Түвшинжаргал, мөн газрын Эрх зүйн дүн шинжилгээний хэлтсийн ахлах зөвлөх Г.Золжаргал, Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн даргын албан үүргийг

түр орлон гүйцэтгэгч Ц.Батбаатар, мөн хэлтсийн Хууль зүйн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх М.Үнэнбат, референт Б.Галсанбат нар байлцав.

Төслийг анхны хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаар Хууль зүйн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнхцэцэг "Их хуралдай" танхимаас танилцуулав.

Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ж.Ганбаатар, Ш.Адьшаа, Н.Алтанхуяг, Л.Мөнхбаатар, С.Ганбаатар, Б.Бат-Эрдэнэ, М.Оюунчимэг нарын тавьсан асуултад ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнхцэцэг, Хүний эрхийн Үндэсний Комиссын гишүүн Б.Энхболд нар "Их хуралдай" танхимаас, Улсын Их Хурлын гишүүн Ж.Сүхбаатар цахимаар хариулж, тайлбар хийв.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.12-т заасны дагуу Хүний эрх хамгаалагчийн эрх зүйн байдлын тухай хуулийн төслийн талаар Хууль зүйн байнгын хорооноос гаргасан зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалтыг MyParliament программыг ашиглан цахим хэлбэрээр явуулав.

<u>Нэг.Хууль зүйн байнгын хорооны дэмжсэн санал:</u>

Г.Занданшатар: 1.Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнхцэцэг, С.Одонтуяа, Ц.Сандаг-Очир, Ж.Сүхбаатар, Б.Энхбаяр /цаашид "Ажлын хэсэг" гэх/ нарын гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 1.1 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

"1.1.Энэ хуулийн зорилт нь хүний эрх хамгаалагчийн эрх зүйн байдлыг тодорхойлох, хөхиүлэн дэмжих, хүндэтгэх, хамгаалах, үйл ажиллагаа явуулах нөхцөлөөр хангах, хамтран ажиллах, Хүний эрх хамгаалагчийн хорооны бүтэц, зохион байгуулалт, үйл ажиллагаатай холбогдсон харилцааг зохицуулахад оршино." гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 41
Татгалзсан: 20
Бүгд: 61
67.2 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2 дугаар зүйлийн 2.1 дэх хэсгийн "Үндсэн хууль," гэсний дараа "Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хууль," гэж нэмж, 3 дугаар зүйлийн 3.1 дэх хэсгийн "нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа" гэснийг "нутаг дэвсгэрт хүний эрх хамгаалах үйл ажиллагаа явуулсан, явуулж байгаа" гэж, "тодорхойлно" гэснийг "зохицуулна" гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 38
Татгалзсан: 23
Бүгд: 61
62.3 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 3 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 3.2 дахь хэсгийг нэмэх:

“3.2.Гадаад улсын нутаг дэвсгэрт хүний эрх хамгаалах үйл ажиллагаа явуулсан Монгол Улсын иргэний эрх зүйн байдлыг Монгол Улсын олон улсын гэрээний дагуу зохицуулна.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 38
Татгалзсан: 23
Бүгд: 61
62.3 хувийн саналаар дэмжигдлээ.

4.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 4 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“**4 дүгээр зүйл.Хуулийн нэр томьёоны тодорхойлолт**

4.1.Энэ хуульд хэрэглэсэн дараах нэр томьёог доор дурдсан утгаар ойлгоно:

4.1.1.“хүний эрх хамгаалагч” гэж ганцаараа, эсхүл бусадтай эвлэлдэн нэгдэж, хүний эрх хамгаалах үйл ажиллагаа явуулж байгаа, түүнд оролцож байгаа хүнийг;

4.1.2.“хүний эрх хамгаалах үйл ажиллагаа” гэж хүний эрх, эрх чөлөөг хөхиүлэн дэмжиж, хүний эрх, эрх чөлөөг зөрчсөн үйлдэл, эс үйлдэхүйн эсрэг хүчирхийллийн бус, тайван аргаар үзэл бодлоо илэрхийлж, олон улсын эрх зүйн нийтээр хүлээн зөвшөөрсөн хэм хэмжээ, зарчмыг хүндэтгэж, хүний эрхийг хамгаалах;

4.1.3.“хүний эрх хамгаалагчийн эрхийг хамгаалах” гэж төр, хүн, хуулийн этгээд, тодорхой ашиг сонирхлоор нэгдсэн аливаа этгээдийн зүгээс хүний эрх хамгаалагчийн эрх, эрх чөлөөг зөрчихөөс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, зөрчигдсөн эрхийг сэргээн эдлүүлэх, учирсан хохирлыг нөхөн төлүүлэхэд чиглэгдсэн төрийн байгууллагын үүргийг;

4.1.4.“хүний эрх хамгаалагчийн эрхийг хүндэтгэх” гэж төрийн байгууллага хүн, хуулийн этгээд хүний эрх хамгаалагчийн хууль ёсны үйлдлийг таслан зогсоохгүй, саад учруулахгүй, эсхүл эрх, эрх чөлөөнд нь хууль бусаар халдахгүй байх үүргийг;

4.1.5.“хүний эрх хамгаалагчийн эрхийг зөрчих” гэж Хүний эрх хамгаалах үйл ажиллагаатай нь холбогдуулан хүний эрх хамгаалагчид болон түүний гэр бүлийн гишүүн, асран хамгаалагч, хамтран амьдрагч, төрлийн хүн, хууль ёсны төлөөлөгчийг аливаа хэлбэрээр доромжлох, гүтгэх, худал мэдээлэл тараах, ялгаварлан гадуурхах, үйл ажиллагааг нь дэмжихгүй байхыг уриалах, албадах, хүч хэрэглэх, хүч хэрэглэхээр заналхийлэх, мөрдөж мөшгөх, амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгөнд нь гэм хор учруулах үйлдэл, эс үйлдэхүйг;

4.1.6.“эрсдэлийн үнэлгээ” гэж хүний эрх хамгаалагчид болон түүний гэр бүлийн гишүүн, асран хамгаалагч, хамтран амьдрагч, төрлийн хүн, хууль ёсны төлөөлөгчид учирч буй аюул, эрсдэлийн түвшнийг тодорхойлсон дүгнэлтийг.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Л.Мөнхбаатар үг хэлэв.

Зөвшөөрсөн: 35
Татгалзсан: 26
Бүгд: 61
57.4 хувийн саналаар дэмжигдлээ.

5.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 5 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“5 дугаар зүйл.Хүний эрх хамгаалагчийн үйл ажиллагааны үндсэн зарчим

5.1.Хүний эрх хамгаалагч үйл ажиллагаандаа дараах зарчмыг баримтална:

5.1.1.Үндсэн хууль, бусад хуулийг сахин биелүүлэх;

5.1.2.шударга, хүнлэг ёсыг эрхэмлэх;

5.1.3.авлига, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх;

5.1.4.ялгаварлан гадуурхахгүй байх;

5.1.5.бусдын нэр төр, алдар хүнд, эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хүндэтгэх.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 37
Татгалзсан: 26
Бүгд: 63
58.7 хувийн саналаар дэмжигдлээ.

6.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн ХОЁРДУГААР БҮЛГИЙН гарчгийн “ХАМГААЛАГЧИЙН ЭРХ,” гэсний дараа “САНХҮҮЖИЛТ,” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 33
Татгалзсан: 30
Бүгд: 63
52.4 хувийн саналаар дэмжигдлээ.

7.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 6 дугаар зүйлийн 6.1.1 дэх заалтын “хамгаалахад” гэснийг “хамгаалах үйл ажиллагаа явуулах, сайн дураар” гэж, 6.1.2 дахь заалтын “таниулах, тэдгээрийг” гэснийг “олон нийтэд таниулах,” гэж өөрчилж, төслийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“6.1.Хүний эрх хамгаалагч дараах бүрэн эрхтэй:” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 36
Татгалзсан: 27
Бүгд: 63
57.1 хувийн саналаар дэмжигдлээ.

8.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 6.1.5 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“6.1.5.хүний эрх хамгаалах үйл ажиллагаа явуулдаг үндэсний болон гадаад улсын, бүс нутгийн болон олон улсын байгууллагатай харилцах, хамтран ажиллах;” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 37
Татгалзсан: 26
Бүгд: 63
58.7 хувийн саналаар дэмжигдлээ.

9.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 6 дугаар зүйлийн 6.1.7 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“6.1.7.хуулийн дагуу нуцад хамааруулснаас бусад мэдээллийг хүний эрх, эрх чөлөөг хамгаалах зорилгоор төрийн байгууллага, хуулийн этгээдээс хуульд заасан аргаар хайх, олж авах, хэвлэн нийтлэх, хадгалах, бусадтай хуваалцах;” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 39
Татгалзсан: 24
Бүгд: 63
61.9 хувийн саналаар дэмжигдлээ.

10.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 6 дугаар зүйлийн 6.1.9 дэх заалтын “үүнийгээ хүлээн зөвшөөрүүлэхэд нөлөөлөх,” гэснийг, 6.1.10 дахь заалтын “төрийн үйл хэрэгт оролцох,”, “шүүмжлэх,”, “зөвлөмж хүргүүлэх,” гэснийг, 6.1.13 дахь заалтын “хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа” гэснийг, мөн зүйлийн 6.1.4, 6.1.14, 6.1.15, 6.1.18 дахь заалтыг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 37
Татгалзсан: 26
Бүгд: 63
58.7 хувийн саналаар дэмжигдлээ.

11.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 6 дугаар зүйлийн 6.1.6, 6.1.16 дахь заалтыг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 40
Татгалзсан: 23
Бүгд: 63
63.5 хувийн саналаар дэмжигдлээ.

12.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 6 дугаар зүйлийн 6.1.11 дэх заалтын “этгээдийн” гэсний дараа “бичгээр гаргасан” гэж, 6.1.12 дахь заалтын “үйлдлийн талаар” гэсний дараа “холбогдох олон улсын гэрээнд заасан журмын дагуу” гэж нэмж, 6.1.13 дахь заалтын “олон улсын холбогдох хэм хэмжээг” гэснийг “Монгол Улсын олон улсын гэрээг” гэж, 6.1.17 дахь заалтын “сэтгэл санааны болон бодит хохирлоо” гэснийг “эдийн болон эдийн бус хохирлоо хуульд заасан журмын дагуу” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 38
Татгалзсан: 25
Бүгд: 63
60.3 хувийн саналаар дэмжигдлээ.

13.Ажлын хэсгийн гаргасан, Төсөлд доор дурдсан агуулгатай 7 дугаар зүйл нэмэх:

“7 дугаар зүйл.Хүний эрх хамгаалагчийн үйл ажиллагааны санхүүгийн ил тод, нээлттэй байдал

7.1.Хүний эрх хамгаалагчийн үйл ажиллагаа явуулахтай холбогдсон аливаа санхүүгийн нөөц, эх үүсвэр ил тод, нээлттэй байх бөгөөд санхүүгийн нөөц дараах эх үүсвэрээс бүрдэнэ:

7.1.1.хуульд өөрөөр заагаагүй бол хүн, хуулийн этгээдээс өгсөн хандив, тусламж;

7.1.2.хуульд заасны дагуу төрөөс үзүүлсэн мөнгөн болон бусад хэлбэрийн санхүүгийн дэмжлэг;

7.1.3.хууль тогтоомжоор хориглоогүй бусад эх үүсвэр.

7.2.Хүний эрх хамгаалагчийн үйл ажиллагааны санхүүжилтэд дараах нөөц, эх үүсвэрийг хориглоно:

7.2.1.гадаад улсын тусгай албад, түүний халхавч байгууллага болон үндэсний эв нэгдлийг бусниулах, мөнгө угаах, террорист болон экстремист үйл ажиллагаа явуулдаг, санхүүжүүлдэг байгууллага, хувь хүнээс, эсхүл хандивлагч нь тодорхойгүй санхүүжилт авахыг хориглоно;

7.2.2.хуулиар зөвшөөрснөөс бусад аргаар санхүүгийн нөөц, эх үүсвэрийг хайх, хүлээн авах, захиран зарцуулахыг хориглоно.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 37
Татгалзсан: 26
Бүгд: 63
58.7 хувийн саналаар дэмжигдлээ.

14.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 7 дугаар зүйлийн 7.1.1 дэх заалтын “арга” гэсний дараа “хэрэглэж” гэж нэмж, мөн зүйлийн 7.1.2 дахь заалтын “алдар хүнд, нэр төрийг” гэснийг “үйл ажиллагааг” гэж, 7.1.3 дахь заалтын “хүний эрх, эрх чөлөөг, үл хүндэтгэх, зөрчих” гэснийг “бусдын нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндийг гутаах” гэж өөрчлөх гэсэн саналыг гүйцээн боловсруулах чиглэл өгч, санал хураалт явуулаагүй болно.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Д.Цогтбаатар, Ц.Мөнхцэцэг нар үг хэлэв.

15.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн Гуравдугаар бүлгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“ГУРАВДУГААР БҮЛЭГ.ТӨРИЙН БАЙГУУЛЛАГА, АЛБАН ТУШААЛТАН, ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН НИЙТЛЭГ ҮҮРЭГ

8 дугаар зүйл.Нийтлэг үүрэг

8.1.Төрийн байгууллага, албан тушаалтан, хуулийн этгээд хүний эрх хамгаалагчийн үйл ажиллагаанд дараах нийтлэг үүргийг хүлээнэ:

8.1.1.хүний эрх хамгаалагчийн эрхийг хүлээн зөвшөөрөх, зөрчихгүй байх;

8.1.2.үйл ажиллагаанд нь хүндэтгэлтэй хандах;

8.1.3.хүчирхийллийн бус, тайван аргаар үйл ажиллагаа явуулах боломж бүрдүүлэх;

8.1.4.шаардлагатай мэдээллээр хангах;

8.1.5.хуульд заасан үндэслэлгүйгээр хүний эрх хамгаалагчид аливаа хэлбэрээр халдахгүй байх;

8.1.6.хүний эрх хамгаалагчийн үйлдлийг хамгаалах зохицуулалтыг байгууллагын дотоод журамд тусгаж, хэрэгжүүлэх, сургалт зохион байгуулах;

8.1.7.хүний эрх хамгаалагчид халдсан тухай мэдээлэл, гомдлыг шийдвэрлэсэн хариуг бичгээр гомдол гаргагчид болон Хүний эрх хамгаалагчийн хороонд хүргүүлэх.

8.2.Цагдаагийн байгууллага хүний эрх хамгаалагчид халдсан халдлагыг таслан зогсоох, түүнийг өөрийнх нь зөвшөөрснөөр эсхүл энэ хуулийн 11.7-д заасан эрсдэлийн үнэлгээний дүгнэлтийг үндэслэн Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуульд заасан журмын дагуу хамгаалалтад авна.

8.3.Хүний эрх хамгаалагчийн эрх зөрчигдсөн тохиолдолд хуулиар хариуцсан чиг үүргийн хүрээнд шаардлагатай арга хэмжээг шуурхай авч хэрэгжүүлнэ.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 37
Татгалзсан: 26
Бүгд: 63
58.7 хувийн саналаар дэмжигдлээ.

16.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 10 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“**10 дугаар зүйл.Хүний эрх хамгаалагчийн хороо**

10.1.Хүний эрхийн Үндэсний Комиссын /цаашид “Комисс” гэх/ дэргэд хүний эрх хамгаалагчийн эрх зөрчигдсөн эсэх талаар дүгнэлт гаргах чиг үүрэг бүхий орон тооны бус Хүний эрх хамгаалагчийн хороо /цаашид “Хороо” гэх/ ажиллана.

10.2.Комиссын Хүний эрх хамгаалагчийн асуудал эрхэлсэн гишүүн Хорооны дарга байх бөгөөд Хорооны үйл ажиллагааг нэгдсэн зохион байгуулалтаар хангаж ажиллана.

10.3.Хороо үйл ажиллагаагаа бие даан явуулах бөгөөд дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

10.3.1.хүний эрх хамгаалагчийн эрх зөрчигдсөн талаарх гомдол, мэдээллийг хүлээн авах;

10.3.2.гомдол мэдээллийн талаар нотолгоо, баримт, мэдээлэл цуглуулах;

10.3.3.хүний эрх хамгаалагчийг хамгаалах хэрэгцээ шаардлагыг тодорхойлох, энэ хуулийн 11.7-д заасан эрсдэлийн үнэлгээ хийх;

10.3.4.эрсдэлийн үнэлгээнд үндэслэн гаргасан дүгнэлтийг Комиссд хүргүүлэх;

10.3.5.энэ хуулийн хэрэгжилт болон хүний эрх хамгаалагчийн нөхцөл байдалд хяналт шинжилгээ, судалгаа хийж, жил бүр Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх илтгэлд тусгуулах;

10.3.6.гомдол, мэдээллийн сан бүрдүүлэх.

10.4.Хороо нь энэ хуулийн 10.2-т заасан даргаас гадна зургаан гишүүний бүрэлдэхүүнтэй байх бөгөөд энэ хуулийн 11.3-т заасан хоёр нэр дэвшигчийг шууд, бусад дөрвөн гишүүнийг ашгийн төлөө бус хуулийн этгээдийн төлөөлөөс нэр дэвшүүлэн, нээлттэй сонсголоор сонгон шалгаруулж, Комисс батламжилна.

10.5.Хорооны бүрэлдэхүүнийг томилохдоо жендэрийн тэнцвэртэй байдал болон үндэсний хэмжээнд идэвхтэй үйл ажиллагаа явуулж буй хүний эрх хамгаалагчийн олон талт төлөөллийг хангана.

10.6.Хорооны гишүүн үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, үг хэлэх, хэвлэн нийтлэх, шашин шүтэх, эс шүтэх эрх, эрх чөлөөгөө эдлэхдээ өөрийн албан тушаалд хүндэтгэлтэй хандана.

10.7.Хорооны гишүүн улс төрийн намын гишүүнчлэлээс түдгэлзэнэ.

10.8.Хорооны үйл ажиллагааны урсгал зардлыг Комиссын төсөвт тусгах бөгөөд Хорооны гишүүнд урамшуулал олгох журмыг Комисс батална.

10.9.Хорооны ажиллах журмыг Комисс батална.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Т.Аюурсайхан, Б.Жаргалмаа нар үг хэлэв.

Зөвшөөрсөн: 35
Татгалзсан: 28
Бүгд: 63
55.6 хувийн саналаар дэмжигдлээ.

17.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 11 дүгээр зүйлийн 11.1 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“11.1.Ашгийн төлөө бус хуулийн этгээдийн төлөөллөөс Хорооны гишүүнд дараах шаардлагыг хангасан хүнийг нэр дэвшүүлнэ:

11.1.1.хүний эрхийг хамгаалах чиглэлээр үндэсний, эсхүл олон улсын хэмжээнд долоогоос доошгүй жил ажилласан туршлагатай;

11.1.2.хүний эрхийг хамгаалах олон улсын тогтолцоо, эрх зүйн хэм, хэмжээний талаар мэдлэг, туршлагатай;

11.1.3.сүүлийн таван жил улс төрийн намын удирдах албан тушаал эрхэлж байгаагүй.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 35
Татгалзсан: 28
Бүгд: 63
55.6 хувийн саналаар дэмжигдлээ.

18.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 11 дүгээр зүйлийн 11.2 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулж, 11.2, 11.3 дахь хэсэг болгох:

“11.2.Хорооны гишүүнийг ашгийн төлөө бус хуулийн этгээдийн төлөөллөөс дараах үе шатаар сонгоно:

11.2.1.Комисс нь хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, Комисс, Төрийн албаны зөвлөл, Жендэрийн үндэсний хороо, Комиссын дэргэдэх Иргэний нийгмийн зөвлөлийн төлөөллөөс бүрдсэн таван хүний бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг байгуулж, Хорооны гишүүнийг сонгон шалгаруулах ажлыг зохион байгуулах;

11.2.2.ажлын хэсэг Хорооны гишүүнд нэр дэвшигчийг сонгон шалгаруулах тухай зарыг хэвлэл мэдээллийн хэрэгслээр 30 хоногийн хугацаанд нийтэд мэдээлэх;

11.2.3.ажлын хэсэг энэ хуулийн 11.2.2-т заасан хугацаа дуусанаас хойш ажлын гурван өдрийн дотор сонгон шалгаруулалтад бүртгүүлсэн нэр дэвшигчийн хувь хүний нуцад хамаарахаас бусад мэдээллийг Комиссын цахим хуудаст байршуулах;

11.2.4.ажлын хэсэг энэ хуулийн 11.2.3-т заасан мэдээллийг байршуулснаас хойш 14 хоногийн дотор сонирхсон этгээд нэр дэвшигчээс асуух асуулт, саналыг хүлээн авах;

11.2.5.ажлын хэсэг энэ хуулийн 11.1-д заасан шаардлагыг хангасан нэр дэвшигчийн талаар нээлттэй сонсгол зохион байгуулах;

11.2.6.ажлын хэсэг нээлттэй сонсгол зохион байгуулснаас хойш ажлын 5 өдрийн дотор нууц санал хураалт явуулж, хамгийн өндөр оноо авсан нэр дэвшигчээс сул орон тоо гарсан гишүүний тоогоор Хорооны гишүүнээр сонгох.

11.3.Хорооны гишүүнийг сонгон шалгаруулах журмыг Комисс батална.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 38
Татгалзсан: 25
Бүгд: 63
60.3 хувийн саналаар дэмжигдлээ.

19.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 11 дүгээр зүйлийн 11.3 дахь хэсгийн “Хүний эрхийн Үндэсний Комисс” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 37
Татгалзсан: 26
Бүгд: 63
58.7 хувийн саналаар дэмжигдлээ.

20.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 11 дүгээр зүйлийн 11.5 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“11.5.Хорооны гишүүнийг гурван жилийн хугацаагаар зөвхөн нэг удаа сонгоно.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 38
Татгалзсан: 25
Бүгд: 63
60.3 хувийн саналаар дэмжигдлээ.

21.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 11 дүгээр зүйлийн 11.6.3 дахь заалтын “гэмт хэрэг үйлдсэн нь шүүхээр тогтоогдсон.” гэснийг “гэм буруутайд тооцож эрүүгийн хариуцлага хүлээлгэсэн шүүхийн шийдвэр хуулийн хүчин төгөлдөр болсон.” гэж, 11.7 дахь хэсгийн “Хороо боловсруулж, Хүний эрхийн Үндэсний Комиссоос баталж, мөрдүүлнэ.” гэснийг “Комисс батална.” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 39
Татгалзсан: 24
Бүгд: 63
61.9 хувийн саналаар дэмжигдлээ.

22.Ажлын хэсгийн гаргасан, Төсөлд доор дурдсан агуулгатай 12 дугаар зүйл нэмэх:

“**12 дугаар зүйл.Хүний эрх хамгаалагчийн хорооны нэгж**

12.1.Хорооны гишүүнд туслах чиг үүрэг бүхий орон тооны нэгж ажиллах бөгөөд бүтэц, орон тоог Комисс батална.

12.2.Хорооны нэгжийн ажилтан төрийн захиргааны албан хаагч байна.

12.3.Хорооны нэгж нь Комиссын Тамгын газарт харьяалагдах бөгөөд зөвхөн энэ хуулийн 10.2-т заасан чиг үүргийг хэрэгжүүлнэ.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Т.Аюурсайхан үг хэлэв.

Зөвшөөрсөн: 34
Татгалзсан: 29
Бүгд: 63
54.0 хувийн саналаар дэмжигдлээ.

23.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 12 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“**12 дугаар зүйл.Хууль зөрчигчид хүлээлгэх хариуцлага**

12.1.Энэ хуулийг зөрчсөн албан тушаалтны үйлдэл нь гэмт хэрэг, зөрчлийн шинжгүй бол Төрийн албаны тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

12.2.Энэ хуулийг зөрчсөн хүн, хуулийн этгээдэд Эрүүгийн хууль, эсхүл Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 40
Татгалзсан: 23
Бүгд: 63
63.5 хувийн саналаар дэмжигдлээ.

24.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“13.1.Энэ хуулийг 2022 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.” гэсэн саналыг гүйцээн боловсруулах чиглэл өгч, санал хураалт явуулаагүй болно.

<u>Хоёр.Найруулгын шинжтэй саналын томьёолол</u>:

Г.Занданшатар: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2 дугаар зүйлийн 2.1 дэх хэсгийн “эдгээр” гэсний өмнө “болон” гэж, 11 дүгээр зүйлийн 11.6.1 дэх заалтын “захиргааны,”, “тусгай” гэсний өмнө “төрийн” гэж нэмэх.

2.Төслийн 6 дугаар зүйлийн 6.1.12 дахь заалтын “төрийн бус байгууллага, аж ахуйн нэгжийн” гэснийг “хуулийн этгээдийн” гэж, 6.1.13 дахь заалтын “ажиглалт хийх” гэснийг “ажиглагчаар оролцох” гэж, 7 дугаар зүйлийн 7.1.1 дэх заалтын “замаар” гэснийг “аргаар” гэж, 11 дүгээр зүйлийн 11.4 дэх хэсгийн “хүнийг” гэснийг

“этгээдийг” гэж, “Хүний эрх хамгаалагчийг хамгаалах хорооны” гэснийг “Хорооны” гэж өөрчлөх.

3.Төслийн 11 дүгээр зүйлийн 11.4 дэх хэсгийн “Хүний эрхийн Үндэсний” гэснийг хасах.

4.Төслийн талаарх саналын томьёолол дэмжигдсэнтэй холбогдуулан нэр томьёог жигдлэх, зүйл, хэсэг, заалтын дугаарыг нийцүүлж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 37
Татгалзсан: 26
Бүгд: 63
58.7 хувийн саналаар дэмжигдлээ.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.12-т заасны дагуу Хүний эрх хамгаалагчийн эрх зүйн байдлын тухай хуулийн төслийн хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн талаар Хууль зүйн байнгын хорооноос гаргасан зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалтыг MyParliament программыг ашиглан цахим хэлбэрээр явуулав.

Нэг.Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томьёолол:

<u>Нэг.Хууль зүйн байнгын хорооны дэмжсэн санал:</u>

Г.Занданшатар: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн “хуульд” гэснийг “хуулийн 4 дүгээр зүйлд” гэж, “дараах хэсэг,” гэснийг “4.1.4 дэх” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 38
Татгалзсан: 25
Бүгд: 63
60.3 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2 дугаар зүйлийн “, 5.4 дэх” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 38
Татгалзсан: 25
Бүгд: 63
60.3 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 3 дугаар зүйлийн “зүйлийн 21.2 дахь хэсэгт дараахь” гэснийг “зүйлд доор дурдсан агуулгатай 21.2.4 дэх” гэж, мөн зүйлийн 21.2.4 дэх заалтын “мөрдөн байцаагч” гэснийг “мөрдөгч” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 41
Татгалзсан: 22

Бүгд: 63
65.1 хувийн саналаар дэмжигдлээ.

Хоёр.Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томьёолол:

Нэг.Хууль зүйн байнгын хорооны дэмжсэн санал:

Г.Занданшатар: Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“**1 дүгээр зүйл.**Зөрчлийн тухай хуулийн Тавдугаар бүлэгт доор дурдсан агуулгатай 5.20 дугаар зүйл нэмсүгэй:

“**5.20 дугаар зүйл.Хүний эрх хамгаалагчийн эрх зүйн байдлын тухай хууль зөрчих**

1.Хүний эрх хамгаалагчийг доромжлох, гүтгэх, үйл ажиллагааг нь дэмжихгүй байхыг уриалах, албадах арга хэрэглэсэн бол учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг нэг зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

2.Хүний эрх хамгаалагч нь хүчирхийллийн арга хэрэглэж, тайван бус аргаар үйл ажиллагаа явуулсан, явуулахыг уриалсан, хүний эрх хамгаалагчийн үйл ажиллагааг хувийн ашиг сонирхолд ашигласан, бусдын нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндийг гутаасан бол учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг нэг зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.”” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 40
Татгалзсан: 23
Бүгд: 63
63.5 хувийн саналаар дэмжигдлээ.

Зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хурааж дууслаа.

Хүний эрх хамгаалагчийн эрх зүйн байдлын тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Хууль зүйн байнгын хороонд шилжүүлэв.

Уг асуудлыг 11 цаг 47 минутад хэлэлцэж дуусав.

Дэлгэрэнгүй тэмдэглэл

Нэг.Хүний эрх хамгаалагчийн эрх зүйн байдлын тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулна.

Төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Хууль зүйн Байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Цэрэнжамцын Мөнхцэцэг танилцуулна. Мөнхцэцэг гишүүнийг индэрт урьж байна.

Ц.Мөнхцэцэг: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Улсын Их Хурлын гишүүн Д.Цогтбаатараас 2020 оны 5 дугаар сарын 07-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Хүний эрх хамгаалагчийн эрх зүйн байдлын тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг хэлэлцэх эсэх асуудлыг Улсын Их Хурал 2020 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн нэгдсэн хуралдаанаар хэлэлцэж, анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Хууль зүйн байнгын хороонд шилжүүлсэн.

Хууль зүйн байнгын хорооны 2020 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн 10 дугаар тогтоолоор хуулийн төслийг Байнгын хорооны болон чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх үүрэг бүхий ажлын хэсгийг байгуулж, ажлын хэсгийн ахлагчаар Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнхцэцэг, гишүүдэд Улсын Их Хурлын гишүүн С.Одонтуяа, Ц.Сандаг-Очир, Ж.Сүхбаатар, Б.Энхбаяр нар ажилласан болно.

Байнгын хорооны 2021 оны 3 дугаар сарын 24-ний өдрийн хуралдаанаар хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулж, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлд заасны дагуу хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцсэн болно.

Ажлын хэсгээс хүний эрх хамгаалагч үйл ажиллагаандаа Үндсэн хууль болон бусад хуулийг сахин биелүүлэх, авлига, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх, ялгаварлан гадуурхахгүй байх, бусдын нэр төр, алдар хүнд, хууль ёсны ашиг сонирхлыг хүндэтгэх, Хүний эрх хамгаалагчийг хамгаалах хорооны гишүүнийг сонгон шалгаруулах механизмыг тодорхой болгох, хүний эрх хамгаалагчийн эрх зөрчигдсөн талаар гомдол, мэдээллийг хэрхэн шийдвэрлэх, хүний эрх хамгаалах үйл ажиллагааны санхүүгийн нөөц, эх үүсвэр ил, тод, нээлттэй байх зэрэг зарчмын зөрүүтэй санал гаргасныг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн болно.

Хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулах үед Улсын Их Хурлын гишүүн Ш.Раднаасэд хүний эрхийг хамгаалагч гэж хэнийг хэлэх, хүний эрх хамгаалах үйл ажиллагааны санхүүжилтийн талаар, Улсын Их Хурлын гишүүн Д.Цогтбаатар төслийн 7 дугаар зүйлийн 7.1.3 дахь заалтын талаар ажлын хэсгээс гаргасан саналын талаар, Улсын Их Хурлын гишүүн Ж.Ганбаатар хүний эрх хамгаалагчийн үйл ажиллагаанд саад учруулсан иргэн, албан тушаалтанд хэрхэн хариуцлага хүлээлгэх талаар асуулт асууж, хариулт авсан болно. Улсын Их Хурлын гишүүн Н.Алтанхуяг Хүний эрхийн хамгаалагчийн эрх зүйн байдлын тухай хуулийн төсөл Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуультай олон талаараа давхцал үүсгэж байгаа тул хуулийн төслийг дэмжихгүй байгаа бөгөөд хууль санаачлагчийг төслөө татан авах нь зүйтэй талаар санал хэлсэн болно.

Хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Хууль зүйн байнгын хорооны санал, дүгнэлт зарчмын зөрүүтэй саналын томьёоллыг Та бүхэнд тараасан болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Хүний эрх хамгаалагчийн эрх зүйн байдлын тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Хууль зүйн байнгын хорооны санал, дүгнэлт, зарчмын зөрүүтэй саналыг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг Та бүхнээс хүсье. Анхаарал тавьсанд баярлалаа.

Г.Занданшатар: Ажлын хэсгийн гишүүдийг танилцуулъя. Хүний эрхийн Үндэсний Комиссын гишүүн комиссын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч Жаргалсайханы Хунан, Хүний эрхийн Үндэсний Комиссын гишүүн Батцэвэгийн Энхболд нар оролцож байна. Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан асуулт асуух Улсын Их Хурлын гишүүд байна уу? 32 зарчмын зөрүүтэй саналаар санал хураалт. Ганбаатар, Бат-Эрдэнэ гишүүнээр тасаллаа. Жамбалын Ганбаатар гишүүн.

Ж.Ганбаатар: Баярлалаа. Энэ хуулийг нэлээн сайн уншсан. Тэгээд уншаад үзэхээр хүний эрхийг хамгаалах үйл ажиллагаа гэдгийг хүний эрх, эрх чөлөөг хөхиүлэн дэмжих, зөрчсөн үйлдэл, эс үйлдэл, үзэл бодол илэрхийлэх тэгээд нэлээн олон заалтууд байгаа юм. Энэ ер нь яг ямар бодит үйлдэл, үйл ажиллагаа хэрэгжүүлэх вэ гэдэг нь надад сайн ойлгогдохгүй юм л даа. Нэг тайлбарлаж өгөөч гэж ажлын хэсгээс хүсье. Одоо байгаа иргэд эвлэлдэн нэгдээд одоо эрхээ хамгаалж байгаа шүү дээ. Энэнээс одоо юугаараа өөр юм бол гэж, юугаараа өөр юм бэ гэдгийг тайлбарлаж өгөөч. Дараагийн дугаарт нь энэ хүний эрхийг хэн зөрчөөд байгаа юм бэ гэдэг нь гол асуудал шүү дээ. Хэн зөрчөөд байгаа юм бол, тэгэхлээр энэ тодорхой албан тушаалтнууд л байгаа шүү дээ. Тэгэхлээр энэ албан тушаалтнууд хүний эрхийг зөрчсөн тохиолдолд энэ хуулиар ямар арга хэмжээ, ямар хариуцлага оногдуулах вэ гэдгийг асуудлаар Зөрчлийн хууль ярина лээ. Зөрчлийн хууль дээр зөвхөн иргэн, аж ахуйн нэгж гэж байгаа. Төрийн албан хаагч гэж үг нэг ч байхгүй.

Зөрчлийн тухай хуулиар төрийн албан хаагчийг шийтгэдэггүй. Тийм ч учраас энэ зөрчлийн хууль чинь харгис хууль. Зөрчлийн хуулиар зөвхөн иргэн, аж ахуйн нэгжийг торгодог, шийтгэдэг, баривчилдаг, асуудал үүсгэдэг гэсэн үг. Тэгэхлээр энэ хуулийг чинь зөрчиж байгаа гол хүн нь тэр өндөр албан тушаалтан, төрийн өндөр албан тушаалтнууд. Тэгээд энэ Төрийн албаны тухай хуульд эсхүл дагаад өөрчлөлт оруулсан юм уу гэхлээр үгүй юм байна лээ. Тэгэхлээр би хуулийн гол зорилгыг олж харахгүй байгаа юм. Төрийн албаны тухай хуульд эсхүл өөрчлөлт оруулаад хүний эрхийг ингэж ингэж зөрчсөн тохиолдолд ажлаас халагдана, сахилгын хариуцлага оногдуулна, эсвэл эрүүгийн хариуцлага оногдуулна гээд ингээд заах ёстой байх гэж ойлгосон. Гэхдээ би ажлын хэсгээс…/минут дуусав/

Г.Занданшатар: Уул нь хэлэлцэх эсэх дээр Цогтбаатар сайд бас Цогтбаатар гишүүн хариулах ёстой асуултууд бас байна шүү. Мөнхцэцэг Цэрэнжамцын Мөнхцэцэг гишүүн ажлын хэсгийн. Хэлэлцэх эсэх биш анхны хэлэлцүүлэг.

Ц.Мөнхцэцэг: Ганбаатар гишүүний асуултад хариулъя. Тэгэхээр энэ хүний эрх хамгаалагчийн эрх зүйн байдлын тухай хууль бол хүний эрхийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг, хүний эрхийн хамгаалагч энэ дотроо одоо эрүү шүүлт, хүний эрх, хүүхдийн эрх мөн одоо уул уурхай, иргэдийн эрүүл аюулгүй орчинд амьдрах

эрх зэрэг энэ асуудлаар тэмцэл хийдэг хүний эрхийн одоо мэргэшсэн иргэний нийгмийн зүтгэлтэн байгууллагууд, иргэдийн сайн дурын эвсэл, холбоо гэх мэтийн хүний эрхийн чиглэлийн одоо гол зүтгэлтнүүдийг хамгаалах ийм олон улсын механизмыг оруулж ирж байгаа ийм хууль байгаа. Ер нь бол олон улсад бол энэ хоёр чиглэлээр одоо хүний эрхийн хамгаалагчаа хамгаалдаг байна. Үүн дотор одоо Европын холбоо зэрэг бүс нутгийн хүний эрхийн томоохон байгууллагуудтай он удаан жилийн одоо хүний эрхийн зохицуулалт өндөр хөгжсөн орнууд бол Хүний эрхийн хамгаалагчийн тусгай хуулиар явахгүй ерөнхий хуулиудаар зохицуулаад явдаг.

Гэтэл одоо Монгол Улс болон одоо азийн одоо латин америк, африкийн зэрэг одоо шилжиж байгаа буюу одоо нөгөө дарангуйлалд шилжиж байгаа улс орнуудын хувьд хүний эрх хамгаалагчийн тусгай хуультай байх нь зөв гэдгийг бол НҮБ-ын олон улсын хүний эрхийн хороо, НҮБ-ын байгууллагуудаас зөвлөмж гаргасан байдаг. Тийм учраас бид нар энэ асуудлыг бас өнгөрсөн гучин жилийн одоо нөхцөл, өнөөдрийн одоо бас үүсээд байгаа тодорхой байдлуудыг хараад ер нь Хүний эрх хамгаалагчийн тусгай хууль байх нь зүйтэй гэдгийг бол энэ хууль санаачлагчид оруулж ирсэн. Ажлын хэсэг дээр бол бас нэлээн одоо бас ярилцаж хуулийн үндэслэлийг бол дэмжсэн байгаа.

Хоёрдугаар асуулт дээр одоо тодорхой хууль зөрчсөн албан тушаалтнууд ямар хариуцлага хүлээлгэх вэ гэж. Тэгэхээр хүний эрхийн одоо зөрчил гаргадаг гэдэг юм уу, за эсвэл хүний эрх хамгаалагчийн эрхийг зөрчиж байгаа субъектүүд бол үндсэндээ гүйцэтгэх засаглал гэхээсээ илүү одоо шүүхийн процесс дундаа тэр дотор одоо мөрдөн байцаах шатанд мөн одоо нутгийн захиргаа гэх мэтийн одоо төрийн байгууллагын албан тушаалтнууд байдаг. Тийм учраас энэ хуульд бол хэд хэдэн төрлийн энэ хууль зөрчсөн, одоо шийтгэл хүлээлгэх одоо механизм оруулсан байгаа. Хэрэв одоо тухайн…/минут дуусав/

Г.Занданшатар: Жамбалын Ганбаатар гишүүн тодруулъя.

Ж.Ганбаатар: Би Мөнхцэцэг гишүүнийг бол ойлгож байна л даа. Өчнөөн ажлын хэсэг ахалдаг. Тэгээд танд бол нэг их айхтар буруу биш байх. Тэгээд өргөн барьсан хүмүүс нь яах гэж бичиг барьсан юм, одоо энийг тунхгийн шинж чанартай л одоо. Үгүй ээ, энэ хүний эрх зөрчигдөж байгаа бол тэр зөрчиж байгаа хүнийг нь л одоо зөрчүүлэхгүй байх ёстой биз дээ. Гол зорилго нь дахиж хүний эрх битгий зөрчөөч гэж. Тэгээд энд нэг олон улсын юманд нийцүүлнэ, нийцүүлнэ гээд л. Ингээд тэгээд зөрчих юм бол Зөрчлийн тухай хууль. Би хэлээд байна шүү дээ. Зөрчлийн тухай хууль чинь иргэн, аж ахуйн нэгжүүдийг л шийтгэдэг хууль. Төрийн албан хаагч гэж байхгүй. Тэгээд би энийг чинь оруулах гэж зөндөө орилсон. Одоо зөндөө ярьсан. Төрийн албан хаагч гэдэг хүн зүгээр дуртай үедээ л ажлаа хаяад явчихна шүү дээ, бараг шахуу. Тэгэхлээр энэ хууль бол учир дутагдалтай гэж үзэж байгаа юм. Би асуулт асуугаагүй баярлалаа. Тодруулаа.

Г.Занданшатар: Хууль зүйн байнгын хороон дарга Сандагийн Бямбацогт.

С.Бямбацогт: Энэ хуулийн хэлэлцэх эсэх дээр бол сая бас Ганбаатар гишүүний ярьж байгаа асуудал, мөн одоо Алтанхуяг гишүүн, Раднаасэд гишүүн гээд одоо гишүүд бас нэлээн болгоомжилсон зүйл ярьж байсан. Тэгээд нэг яриад нэгэнтээ одоо Их Хурал хэлэлцэх эсэхийг нь шийдчихсэн учраас хэлэлцээд явж байгаа анхны хэлэлцүүл хийгдэж байна. Төрийн албан хаагчдын холбоотой хуульд бас тодорхой заалтууд орсон. Хуулийн гуравдугаар бүлэг дээр төрийн

байгууллага, албан тушаалтан, хуулийн этгээдийн хүлээх нийтлэг үүрэг гэсэн нийтдээ одоо гурван зүйлээр арван хэдэн заалтаар үүрэг хүлээлгэчихсэн байгаа. Энэ хүлээсэн үүргээ зөрчих юм бол арван гуравдугаар зүйл дээр хууль зөрчиж хүлээлгэх хариуцлага дээр энэ хуулийг зөрчсөн албан тушаалтны үйлдэл нь гэмт хэрэг, зөрчлийн шинжгүй бол Төрийн албаны тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

Энэ хуулийг зөрчсөн хүн, хуулийн этгээдэд гэмт хэрэг шинжгүй бол Зөрчлийн хуулийн хариуцлага хүлээлгэнэ. Гэмт хэргийн шинжтэй бол төрийн албан хаагчид ч тэр албан байгууллага, аж ахуйн нэгж гэсэн Эрүүгийн хуулийн хариуцлага хүлээснийг тодорхой болчихсон. Өөрөөр хэлэх юм бол иргэн, аж ахуйн нэгж, төрийн албан тушаалтан адилхан хуулийн хариуцлага хүлээлгэх ийм заалтыг их тодорхой оруулж өгсөн байгаа гэдгийг хэлье.

Г.Занданшатар: Ширнэнбаньдын Адьшаа гишүүн.

Ш.Адьшаа: Энэ өдрийн мэнд дэвшүүлье. Энэ хуулийн төслийг хэлэлцэхийг дэмжиж байгаа. Өнөөдөр хүний эрхийг хамгаалах, хүний эрх чөлөөг хамгаалах, зөрчигдсөн эрхийг сэргээх асуудал бол ардчилал, хүний эрх, эрх чөлөөг дээдэлсэн, парламентын засаглалтай энэ улсын амин чухал нэг бодлого байх ёстой гэсэн ийм байр суурьтай байна. Монгол улсын нэгдэн орсон олон улсын гэрээ хэлэлцээрт Монгол Улсын хүлээх үүрэг хариуцлага гэж байгаа. Энэ үүргийнхээ хүрээнд ч гэсэн өнөөдөр Монгол Улс хүний эрх, эрх чөлөөний асуудлыг тусгай хуулиар зохицуулж энэ асуудалд төр, олон нийтийн байгууллага, иргэдийн одоо үйл ажиллагааг зохион байгуулах, энэ эрх зүйн баримт бичгийг гаргах асуудал бол хамгийн чухал. Монгол Улсаас олон улсын өмнө хүлээсэн үүрэг, хариуцлагын нэг хэлбэр байх гэж ингэж ойлгож байгаа. Өнөөдөр энэнээс болгоомжилж байгаа асуудал байгааг бас үгүйсгэхгүй. Гэхдээ өнөөдөр энэ Хүний эрхийн Үндэсний Комисс гэдэг энэ байгууллага энэ хүний эрхийг хамгаалах талаар бас шинэчлэл хийх шаардлагатай байгаа. Өчигдөр би Байнгын хороон дээр ч хэлсэн. Тэр иргэн Чимгээгийн эрх зөрчсөн асуудлыг өнөөдөр шалгах, тэр эрх нь зөрчигдсөн, зөрчигдөөгүй дүгнэлт гаргах асуудлыг шийдвэрлэх талаар сая Их Хурлын дарга ч бас сая ярилаа. Тэр хэлэлцүүлэг хийе энэ тэр гэх дээр болохгүй байна гэж. Үгүй ээ, одоо ийм юм яриад байвал бид нар өнөөдөр хүний эрх…/минут дуусав/

Г.Занданшатар: Адьшаа гишүүн нэг минут.

Ш.Адьшаа: Хүний эрхийг хамгаалах, шударга ёс, эрх чөлөөг тунхаглан зарлах энэ асуудлыг хаана ярих юм өнөөдөр. Ийм юм нь болохгүй, тийм юм нь болохгүй байна гээд байсаар байтал энэ чинь одоо зургаа, долоон жил тэр хүний эрх зөрчигдсөн асуудал яригдсаар яригдаад энэ парламентын хугацааг дуусгах юм уу, ямар санаа зорилго байна, ямар бодлого байна. Эрх баригч намын Хууль зүйн сайд нь, Ерөнхий сайд нь ийм байна гэж хэлдэг. Гэтэл тэрний доод талын хүмүүс нь одоо ийм хууль чинь ийм болохгүй байна, байхгүй юм байна гээд ийм юм яриад ингээд байгаад байх юм. Хүний эрх зөрчигдсөн бол үнэхээр ардчилсан парламентын засаглалтай, шүүх хуулийг дээдэлсэн байгууллага мөн юм бол улс мөн юм бол энийг шийд. Өнөөдөр ийм юм яриад аргацаасан байдлаар цаг хугацаа хождог энэ байдлыг цаана нь бас нөлөөллийн асуудал байна гэж би хардаж байна. Энэ асуудлыг өнөөдөр Хүний эрхийн Үндэсний Комисс энэ Хууль зүйн байнгын хороо…/минут дуусав/

Г.Занданшатар: Үг болчихлоо доо. Мөнхцэцэг гишүүн хариулах юм уу? Цэрэнжамцын Мөнхцэцэг гишүүн.

Ц.Мөнхцэцэг: Адьшаа гишүүний энэ санаа зовж байгаа энэ асуудал бол үнэхээр чухал асуудал. Ер нь одоо хүний эрхийн олон улсын гэрээ конвенцууд, Монгол Улсын Үндсэн хууль болон бусад хуулиар хүний эрхийг одоо баталгаажуулсан боловч шиг яг тодорхой, одоо үйл явц тодорхой процессын шатандаа асар их зөрчил гарч байгаа. Түүний нэг нь бол энэ иргэн чимгээ болон одоо энэ эрүүдэн шүүсэн асуудал байгаа. Энэ асуудлаар одоо Улсын Их Хурлын Амартүвшин бид хоёрын зүгээс Улсын Их Хуралд хүний эрхийн талаар ерөнхий хяналтын нийтийн сонсгол хийхээр одоо бичиг өргөн барьсан байгаа. Мөн энэ хуулийг одоо энэ судлах явцдаа энэ хэргийн одоо өнөөдрийн нөхцөл байдлын хувьд бол улсын нууцын зэрэглэлтэй байгаа учраас энэ асуудлыг одоо нийтийн сонсголын түвшинд болон бусад түвшинд хэлэлцэхэд хүндрэл учирч байгаа. Тийм учраас одоо өнөөдөр Амартүвшин гишүүн бид хоёрын зүгээс иргэн Чимээгийн одоо эрүүдэн шүүсэн асуудлаарх хэргийг ил болгох тухай албан хүсэлтийг бол ерөнхий сайдад өргөн барина. Ингэж байж бид нар энэ хэргийг одоо эрүүдэн шүүсэн хэсэг, хүний эрх зөрчигдсөн эсэх болон одоо бусад нөхцөл байдлыг тодруулах ийм боломжтой болно. Тийм учраас Адьшаа гишүүндээ баярлалаа. Энэ тэмцэлд ингээд бас хамтран зүтгээд яваарай гэж хэлэх, баярлалаа.

Г.Занданшатар: Тэр хэргийг тусгаарлаж байж л салгахгүй бол мөрдөн байцаалтын шатанд явж байгаа хэрэг бол нууцаас ил гаргачхаж болох уу, үгүй юу гэдгийг бас. Норовын Алтанхуяг гишүүн.

Н.Алтанхуяг: Би Байнгын хороон дээр их тодорхой санал хэлсэн юм. Энэ хүний, ер нь анх энэ хуулийн төслийг Цогтбаатар гишүүн өргөн барихад нь хэлэлцэх үед нь би хэлсэн шүү дээ. Хүний эрх хамгаалагчийн эрх зүйн байдлын тухай хуулийг хэлэлцэх шаардлагагүй юм, нэгдүгээрт энэ дотор бол ингээд бичиж байгаа зүйл нь бол Монгол Улсын Үндсэн хуулийн нэлээн олон зүйлийг авчраад биччихсэн байдаг юм. Тэр тэртээ тэргүй байгаа эрх. Нөгөө талаасаа нэлээн бичсэн маш их олон зүйл бол Хүний эрхийн Үндэсний Комиссын одоо хийх ажилтай давхардсан зүйл байдаг юм. Гуравт нь бол манайд энэ хүний эрхийн байгууллага мундахгүй байна. Ажлаа хийе. Одоо нэг таван хүнтэй комисс байгуулсан, одоо дээр нь нэмээд долоон хүнтэй хүний эрхийн хороо, хамгаалагчийн эрх хороо гэж яах гээд байгаа юм бэ? Энд одоо ажил хий л дээ. Улаан цайм улс орон даяар чинь хүний нүдэн дээр хүнийг эрүүдэн шүүгээд тамлаад зовоочихсон байхад энийг шийдэж чадахгүй мөртөө дахиад долоон хүн шалгаруулаад нэг хороо байгуулна гээд яваад байхаар чинь би болохгүй байна. Энийгээ боль.

Өчигдөр би Цогтбаатарт уг нь эхлээд элэгсэг дотноор хэлсэн юм. Чи татаад авчих, наад хуулиа битгий ингэж ажил удаад бай л даа гэсэн. Тэгээд би та нарт хэлье. Энэ хууль дотор ийм өгүүлбэр байгаа. Үндэсний гадаад улсын, бүс нутгийн эсхүл бол олон улсын байгууллага, эвсэл сүлжээтэй хамтран ажиллах. Энэ Монгол улс юм уу, энэ гадаадын одоо хүмүүсийн гар хөл болдог улс юм уу? Гаднын байгууллагаас мөнгө төгрөг авна гэсэн ийм л хуулийн төсөл байгаа юм. Юу хийх гээд байгаа юм энүүгээр. Тэгэхээр энийгээ, ингээд Занданшатар дарга та нар тэр нэг жаран хэдийнхээ бүлэг дээр ярьж байгаад татаад авчих л даа. Яах гэсэн юм бэ? Энүүгээр ямар ч өөдтэй юм хийгдэхгүй. Тэгээд хэдүүлээ, бодит ажил руугаа оръё. Тэр одоо шоронг нь томилогдож байгаа хүмүүсийг гаргая, тийм ээ, жаахан бодитой юм хийе л дээ. Гурван хувийнхаа зээлийг Их Хурал дээрээ ярья. Энэ амьдрал руугаа оръё л доо. Одоо ингээд л байгууллага байгуулаад л, яриад л

байтал одоо ер нь утга алга. Ард түмэн бид нараас өөр юм дайчин давшингуй, хурдтай…/минут дуусав/

Г.Занданшатар: Алтанхуяг гишүүн нэг минут.

Н.Алтанхуяг: Дайчин давшингуй, хурдтай, тодорхой ажиллахыг шаардаад байдаг. Тэгээд нэг шийдвэр гаргах юм. Хойноос нь. Үгүй ээ, одоо үндэс Хүний эрхийн Үндэсний Комиссын хажууд эд нарын байгуулдаг хороо гэж одоо юу байх юм бэ? Үгүй ээ, ямар хайран цаг авдаг юм бэ, энэ чинь Улсын Их Хурлын хайран алтан цаг шүү дээ. Тэгээд энэ асуудлуудыг шийдье л дээ. Тэр нууцаас гаргаж болохгүй байгаа юмыг нууцаасаа гарга л даа, энэ чинь төрийн эрх барих дээд байгууллага бид нар шийдэж болно шүү дээ. Юугаа нуугаад байдаг юм бэ? Хэнийг хаацайлаад байдаг юм бэ? Ямар хулгайч дээрэмчдийг энэ хорин хэдэн жил хамгаалаад байгаа юм бэ. Ийм, ийм асуудлууд шийдмээр байна. Энэ хуулийн төслийг та нар нэг завсарлага авч байгаад би уг нь надад эрх алга л даа. Завсарлага авч байгаа та нар нэг бүлэг дээрээ яриад жаахан детальны үзвэл та нар татаад л авчихна л даа. Энэ ямар ч ач холбогдолгүй шүү Занданшатар даргаа.

Г.Занданшатар: Энэ хууль хэлэлцэх эсэх нь шийдэгдсэн, дэг журмаараа явж байгаа. Намын бүлгүүдээр хэлэлцэгдсэн. Тэгээд ер нь манай энэ ойлголтын нэг зөрүү байгааг бид хаанаа анхаарах хэрэгтэй байгаа юм. Ерөөсөө төр бүх ажлыг хийнэ. Төр хүний эрхийг хамгаална гэсэн эсвэл зөрчинө гэсэн ийм нэг логиктой үздэг. Тийм учраас бидний хийж боловсруулсан бүх хууль дандаа төрийн байгууллагуудаар Хууль зүй, дотоод хэргийн яам дээр боловсруулагдаад оролцдог хүмүүс нь прокурор, мөрдөгч нар хэрэг илрүүлэхэд л, аль эсвэл төрийн эрх ашгийг хангахад л чиглэсэн нь дандаа хууль тогтоомж баталдаг учраас болохоос биш хүний эрхийг хамгаалах Үндсэн хуулийн энэ үндсэн зарчимд нийцүүлэх, хууль тогтоогч нар энэ хүний эрхийг дээдлэх гол зарчимдаа тулгуурлаж ерөөсөө ханддаггүй нэг илрэл нь энэ. Тийм учраас дандаа энэ төр хийж байх ёстой. Энэ иргэний нийгмийн байгууллагууд нэгдээд хороо байгуулаад тэр чинь төрийн байгууллага байгуулж байгаа хэрэг биш шүү дээ. Зохион байгуулалтад оруулаад ер нь энэ ардчилсан нийгэм гэдэг чинь иргэдийн оролцоог хангаж байж явдаг юм байна шүү дээ. Алтанхуяг сайдаа та одоо ардчиллыг анхнаас нь эхлүүлж, тэмцэж байсан улсууд чинь.

Тэгээд энэ хүний эрхийг хамгаалуулагчийн энэ нөхцөл байдлыг бий болгож байж Хүний эрхийн Комиссын хэдхэн гишүүн нь улс орон даяар хүний эрхийн зөрчлийг, бүх салбарт бизнесийн эрх, өмчлөх эрх, амьд явах эрх, тэр үндсэн хуульд заасан арван зургаадугаар зүйлд заасан арван найман эрхийг хангаж чадахгүй ээ. Ийм учраас иргэний нийгэм, иргэдийн оролцоотойгоор л энэ иргэд эрхээ өөрсдөө хамгаалж чаддаг энэ тогтолцоог бүрдүүлэхгүй бол дандаа төр бүх юмыг шийдэж өгдөг нэг гэсэн ойлголт, хуучны ойлголт. Тийм учраас энэ хууль бол олон улсын жишигтэй ч гэсэн тэр хүний эрх, ардчиллыг дээдэлдэг улс болгонд энийг мөрдөж хэрэгжүүлж байдаг ийм зарчимтай учраас тэр ойлголтынхоо нь харж явах нь зүйтэй юм байна лээ. Тийм учраас бид бас тэр нэг өнгөрсөн зууны сэтгэлгээнээсээ салах цаг болсон байх юм. Ингээд Лхагвын Мөнхбаатар гишүүн цахимаар асуулт асууна.

Л.Мөнхбаатар: Сонсогдож байна уу, сонсож байна уу?

Г.Занданшатар: Сонсож байна.

Л.Мөнхбаатар: Хүний эрхийг хамгаалагчийн эрх зүйн байдлын тухай хууль бол батлагдан гарах нь зүйтэй. Энэ угаасаа НҮБ-ын одоо загвар хууль гарчихсан байдаг. Тэр үүнд нийцүүлээд л хийж байгаа хэрэг юм. Гэхдээ энэ дотор бас анхаарах зүйлүүд бол байна. Сая Алтанхуяг гишүүн бас хэлж байгаа тодорхой асуудал ярихдаа. Энэ дотор гэхэд тухайлбал одоо энэ анхны хэлэлцүүлэгтэй холбогдуулаад хэлэхэд бол энэ Хүний эрхийн Комиссын дэргэд Хүний эрхийг хамгаалагчийн хороо гээд долоон хүний одоо орон тоотой ийм хороо байгуулагдах нь. Энэ ер нь одоо ингээд орон тооны бус хороо, орон тооны бус зөвлөлүүд одоо олноор байгуулагдан ажилладаг. Эдгээр бол төдийлөн үр дүнд бол хүрдэггүй нь бол одоо та бүхэн бас мэдэж байгаа.

Тэгэхээр ийм хоёрын хооронд ийм орон тооны хороо бус үүнийг нь Хүний эрх хамгаалагчийн одоо эрхийг хамгаалах гээд байгаа асуудал шүү дээ. Тэгэхээр энэ эрхийг нь бол Хүний эрхийн Үндэсний Комисст нь өгчхөж болдоггүй юм уу гэж өгчихмөөр байгаад байгаа юм. Ингэх юм бол Хүний эрхийн Комиссын ажлын албанд энэ чиглэлээр ажиллах нэг нэгж гаргаад өгчихнө. Ингэх юм бол илүү үр дүнтэй ажилламаар харагдаад байна. Ерөөсөө угаасаа энэ хуульд ч гэсэн энэ орон тооны бус хороон дотроо орон тооны бус орон тооны нэгжтэй байна гэсэн ийм санал бас харагдаж байгаа юм байна лээ шүү дээ. Тийм учраас энийгээ бол Хүний эрхийн Комисстой нэгтгээд явчихъя, Хүний эрхийн Комисс гээд сая тавигдаад одоо хүмүүс нь томилогдоод ажиллаж байгаа, энэ рүүгээ нэгтгээд явчихвал яасан юм бэ. Тэгэхгүй бол энэ орон тооны бус хороо нь нэг дүгнэлт гаргадаг, тэрийгээ Үндэсний комисст хүргүүлдэг шийдвэр гаргадаггүй. Ингээд нэг тийм дамжуулагчийг гүйцэтгэх төдий л одоо байх ийм байгууллага байхаар харагдаад байгаа юм. Тийм болохоор үндэсний Хүний эрхийн Комиссын гишүүдийг одоо нийтийн сонсгол хийж, хүний эрхийн боловсрол, мэдлэг мэдрэмжтэй ийм хүмүүсийг л одоо бид нар сонгосон гэж шүү дээ. Тийм учраас энэ ажлыг хийгээд явах боломжтой байна гэж одоо үзэж байгаа юм.

Хоёрдугаарт энэ хорооноос бие даасан байдлаар үйл ажиллагаа явуулах энэ тал дээр бас би бас нэг эргэлзээ байгаа нэг тийм зүйл байна. Орон тооны бус хороонд комиссын төсвөөс санхүүжээд ажлын алба нь комисст харьяалагдаад, дарга нь комиссын гишүүн байна гэхээр одоо энэ бие даасан байдлаар үйл ажиллагаа явуулах гэдэг агуулга нь бол байхгүй харагдаад байгаа юм. Ийм учраас эдгээрийг одоо харгалзан үзэж, бас энэ анхны хэлэлцүүлэг дээрээ засаад явах боломж байна уу гэдгийг одоо ажлын хэсгийн гишүүдээс асууя гэж бодож байна.

Г.Занданшатар: Мөнхцэцэг гишүүн.

Ц.Мөнхцэцэг: Мөнхбаатар гишүүний асуултад хариулъя. Тэгэхээр энэ хороо бол яг хүний эрх хамгаалагчдын зөрчигдсөн эрхийг нь сэргээх, эрсдэл учирсан тохиолдолд хамгаалалтад авах, дүгнэлт гаргах, мөн одоо холбогдох албан тушаалтан, одоо байгууллагууд руу асуудлыг тавих ийм одоо эрхтэй байгууллага байгаа. Ер нь бол өнгөрсөн гучин жилийн хугацаанд, ялангуяа одоо энэ хөдөө орон нутагт хүний эрхийн зөрчил маш их гарч байгаа. Уул уурхай, орон нутгийн компаниуд, иргэдийн одоо тэмцэл, хөдөлгөөн, малчдын одоо бэлчээрээ хамгаалах гэсэн гэх мэт. Энэ одоо өргөн уудам газар нутагт хүний эрхийн зорилго одоо газар сайгүй гарч байна. Энэ болгонд одоо иргэний нийгмээ төлөөлөөд гэдэг юм уу, иргэдийн төлөөлөл болсон энэ хүний эрх хамгаалагч маань одоо маш олон одоо хүрээнд идэвхтэй ажиллах боломжтой.

Тийм учраас энэ Хүний эрх хамгаалагчийн хороо маань иргэний нийгмийн

одоо үүсэл санаачилга гэдэг юм уу, иргэний нийгмийн одоо субъект гэдэг утгаараа энэ хүний эрхийг хамгаалах үндэсний механизм дотроос онцгой үүрэг гүйцэтгэх ийм шинэ одоо тогтолцоо болж байгаа. Хүний эрхийн Үндэсний Комисс бол хүний эрхийн одоо хэрэгжилтийг хангах одоо төрийн байгууллага, төрийн механизм гэдгээр. Тийм учраас бид нарын одоо нөгөө иргэний нийгэм болон одоо төрийн байгууллага хамтран хүний эрхийн одоо төлөө зүтгэх ийм механизм хослон ажиллана гэж ойлгох ёстой. Тэгээд хороо бол одоо нөгөө олон улсын бүтцээр олон улсын стандартын дагуу хүний эрхийн чиглэлийн мэргэшсэн зүтгэлтнүүдийг сонгон шалгаруулж нээлттэй одоо оролцооны үндсэн дээр бий болж ажиллана.

Тэгээд мөн одоо хороо бол орон тооны бус боловч нэгж нь орон тооны бөгөөд Хүний эрхийн Комисстойгоо ингээд хамтран ажил явах ёстой. Ер нь бол бид нар энэ асуудлаар, бас ингээд хэдэн сарын турш Хүний эрхийн Комисстой хамтран нөхцөл байдал, одоо хүний эрхийн одоо чадамж, тэгээд иргэний нийгмийн оролцоо зэргийг маш их ярилцсаны үндсэн дээр энэ хууль маань одоо яах аргагүй энэ хорооны нэгжээ байгуулаад явах нь зүйтэй гэдэг дээр бол шийдэлд хүрчихсэн байгаа. Баярлалаа.

Г.Занданшатар: Тэгээд янзлаад явах нь байна. Одоо эрхэм гишүүн Сайнхүүгийн Ганбаатар.

С.Ганбаатар: Энэ хуулийг сайн судалж уншлаа. Хүний эрх Монголд хамгийн их зөрчигддөг, бас анхаарах ёстой зүйл. Хүний эрх бол шийдвэр гаргагч нараас л иргэнийг яаж хамгаалах тухай л хууль шүү дээ. Адууны хулгайч бол эрүүгийн хариуцлагад үүрдэг. Хортой архи хийгээд зарсан аж ахуйн нэгжийг бол эрүүгийн хариуцлага үүрдэг, эрүүгийн асуудал. Харин шийдвэр гаргагч дарга нар гарын үсгээ худалдаж ард түмнийг хохироовол энэ хүний эрхийн асуудал болдог. Хүний эрхийн конвенцын эхний хэсэг дээр нь байдаг шүү. Хүний эрхийг зөрчигч бол шийдвэр гаргагч гэж байгаа юм. Бүр төр, төрөөс яаж иргэнийг хамгаалах тухай л хууль. Тэгэхлээр миний асуулт, нэгдүгээр асуулт. Хүний эрх бол орлого ажилтай байх ядуурлаас хүний гаргах явдал. Гурван сая хүнийг ажил орлоготой болгох, уул уурхайн баялгийг нь Ерөнхий сайд нь гаднынхантай нийлээд худалдаад зараад идээд уучихсан байгаа энэ аймшигтай асуудал хүний эрхийн зөрчил мөн үү? Надад хариулж өгөөч, би одоо энийг л тодруулмаар байна. Гаднынханд найраад олон сая гурван сая хүнийг ажилтай орлоготой болгох баялгийг нь цөлмөөд дээрэмдчихсэн энэ хүний эрхийн зөрчил мөн үү?

Хоёрдугаар асуулт. Үүнийг нь ярьж тэмцэж хүмүүст ойлгуулж хичээж байгаа хүний нэр хүндийг нь гутааж харлуулж тэр уул уурхайн баялгаасаа идэж уусан мөнгөөрөө хэвлэл мэдээллийг худалдаж авч маш ихээр сэтгэл зүйн болон нэр хүндийн дарамт үзүүлж байгаа явдлыг энэ хууль дээр хүний эрхийн хамгаалагч гэж үзээд хамгаалах ямар заалтууд байгаа вэ? Яг тодорхой заалтууд бий юу? Гуравдугаар асуулт. Үйлдвэрчний эвлэл бол ажил олгогч, бизнес, эрхлэгч төрийн, ялангуяа төрийн өмчийн компаниуд дээр хамгийн их хүний эрх зөрчигддөг, хамгийн их дээрэлхүүлдэг.

Г.Занданшатар: Мөнхцэцэг гишүүн. Тэгэхээр энэ шүүхийн шатанд хүний эрхийн зөрчил бас түгээмэл байдаг. Тэгэхдээ Үндсэн хууль болон олон улсын гэрээ конвенцоор иргэн бол одоо шударга шүүхээр шийтгэл хүлээх ёстой. Шүүх бол хараат бус ямар нэг одоо эдийн засгийн болон одоо бусад юунаас хараат бусаар ажиллаж шүүхийн хуулийн дагуу шударга шийдвэр гаргах ёстой. Тийм учраас одоо иргэний эрхийг хамгаалах, ялангуяа одоо шүүхийн шатанд одоо хүний

эрхийг хамгаалах асуудал бол энэ хүний эрх хамгаалагч нарын бас гол одоо үүрэг байгаа. Ер нь ингээд өнгөрсөн жилүүдийн одоо Хүний эрхийн Комиссын Үндэсний тайлан илтгэлээс ингээд үзэхээр бол процессын шатанд буюу одоо хэрэг мөрдөн байцаах шатандаа бол асар их зөрчил гарч ирсэн ийм одоо кэйс тохиолууд зөндөө байна.

Харамсалтай нь одоо тодорхой нөхцөлд бас эрүүдэн шүүсэн асуудлууд бол байгаа боловч нэлээд олон тохиолдолд энэ бол хэрэгсэхгүй, нотлох баримт хангалтгүй гэдгээр одоо буцаагдсан байгаа. Ер нь бол энэ дашрамд ингээд хэлэхэд бол хүний эрхийн асуудал бол ерөөсөө одоо тухайн улс үндэстэн гэхээсээ илүү мөн одоо хүн төрөлхтний томоохон асуудал. Хүний эрхийн зөрчлүүдийг бол тодорхой нөхцөлд бол ноцтой зөрчил гэж, тэр тусмаа одоо эрүүдэн шүүх зэрэг асуудлыг бол үздэг. Тэгэхээр энэ өнөөдрийн энэ хууль бол хүний эрхийг одоо бүх шатандаа, тэр дотроо одоо энэ хөдөлмөрийн нөхцөл, хөдөлмөрийн аюулгүй байдал, ялангуяа одоо үйлдвэрчний эвлэлийнхний хувьд бол энэ хүний эрхийн тэмцэгч гэдэг утгаараа бол энэ хуулийн бас хамгаалалтад орж явах ёстой. Тэгэхээр одоо тухайн үйл ажиллагаа явуулж байгаа тохиолдолд эрсдэл учирсан бол хороо энэ дээр дүгнэлт гаргаад нөхөн төлүүлэх, хохирлыг барагдуулах ийм тодорхой заалтууд бол орсон байгаа.

Г.Занданшатар: Ганбаатар гишүүн тодруулъя нэг минут.

С.Ганбаатар: Асуултад хариулсанд баярлалаа. Таван толгой, Оюу толгой, Эрдэнэтийг хага базаж, эндээс Монголын ард түмнийг ажилтай орлоготой ядуурлаас нь гаргах тэр боломжийг нь хулгайлж байгаа бүлэглэл, дээрэмчид бол Монголын хамгийн том хүний эрхийн зөрчигчид юм. Тэднийг бол тэд бол одоо Улсын Их Хурлыг ч хага базчихсан. Тэгэхлээр өнөөдөр энэ бол хүний эрхийн хамгийн ноцтой асуудал. Шийдвэр гаргаснаар Ерөнхий сайд нь уул уурхайн баялгаа ард түмэндээ ажилгүйдэл, ядуурлыг нь шийднэ гэж гарын үсгээ зурах ёстой. Энэ гарын үсгээ гаднынханд худалдаж, илт давуу байдал бий болгож, ард түмнээ ажилгүй, ядуу, орлогогүй болгоно гэдэг бол хүний эрхийн битгий хэл хүн төрөлхтний геноцидоос илүү аюултай гэмт хэрэг. Энэ тал дээр хүний эрхийг хамгаалах энэ зүйл заалт энд юу ч алга. Энийг ярихаасаа ч гишүүд айж байгаа. Хэвлэл мэдээллээр энэ тухай гаргах ч боломж байхгүй. Тэгэхлээр…/минут дуусав/

Г.Занданшатар: Мөнхцэцэг гишүүн.

Ц.Мөнхцэцэг: Тэгэхээр Монгол ардын намын одоо сонгуулийн эрхэм зорилго мөрийн хөтөлбөрт бол шүүхийн шударга ёсыг тогтоох, шударга ёсыг нийгмийн одоо бүх түвшинд бий болгох энэ одоо гол зорилготой хоёр мянга хорин оны Их Хурлын сонгуульд орсон. Тэгээд Монголын ард түмэн энэ дээр бол маш дэмжлэг хүлээлгэж нийгмийн бүх салбар, тэр дотроо одоо шүүх засаглалын шударга ёсыг тогтоох, иргэн шударга шүүхээр шүүлгэх, мөн одоо Монгол Улсын баялаг иргэн бүр тэгш шударга хуваарилагдах энэ асуудлаар бол Монгол ардын намын одоо их намын мөрийн хөтөлбөр, Их Хурлын одоо олонх болсон Монгол ардын нам бол онцгойлон ажиллаж байгаа. Тэгэхээр бид нарын одоо өнгөрсөн намрын чуулганаар өргөн барьсан Шүүхийн тухай хууль маань одоо энэ шүүхийн шатан дахь шударга бусын хонгилыг нураах шүүгчид одоо хараат бусаар ажиллах ёс зүйтэй, хариуцлагатай, хараат бус шүүхийн тогтолцоог дэмжихэд бол гол үүрэгтэй болж байгаа. Тэгэхээр энэ хуулийн хэрэгжилт маань одоо амжилттай сайн явах. Энэ дээр одоо манай Их Хурлаас, Хууль зүйн байнгын хорооноос гаргасан Шүүхийн хуулийн тухай ажлын хэсэг бол энэ дээр хяналт тавиад явна.

Тэгээд цаашид одоо энэ баялгийн шударга бус хуваарилалтыг арилгах, нийгмийн тэгш бус байдлыг багасгах тал дээр бол дараа дараагийн хуулиуд баялгийн сангийн…/минут дуусав/

Г.Занданшатар: Бадмаанямбуугийн Бат-Эрдэнэ гишүүн.

Б.Бат-Эрдэнэ: Баярлалаа. Хуулийн төслийг бол дэмжиж байгаа. Тэгээд бид бол Үндсэн хуульдаа хүний эрх, эрх чөлөөг баталгаатай ханган эдлүүлнэ, хүмүүнлэг иргэний ардчилсан ийм нийгмийг байгуулна гэж ингэж тунхаглаад одоо үндсэндээ гучин жил болох гэж байна шүү дээ. Тэгээд харамсалтай нь бол энэ зорилт маань одоо ханган биелүүлэгдсэн үү гэхэд одоо эргэлзээтэй. Та бид хоёрын ярьж байгаа ер нь Зоригийн аллагатай холбоотой холбогдсон хүмүүсийг эрүүдэн шүүсэнтэй холбогдсон ажил бол асуудал бол нэг хэсэг яригдаж байгаад тэгээд орхигдчихлоо шүү дээ. Тэгээд тийм учраас энэ шинэ Засгийн газар Оюун-Эрдэнийн Засгийн газрыг байгуулагдах үеэр бол би Их Хурал дээр энэ асуудлыг анх хөндөж тавьсан. Энэ хөндөж тавьсны дагуу Ерөнхий сайд онцгойлон анхаарч энэ үйл явдлууд өрнөж байгаа гэдгийг та бүхэн маань та мэдэж байгаа. Ер нь одоо энэ хүний эрхийг хамгаалахтай холбоотой асуудал дээр онцгой анхаарахгүй бол энэ хууль хяналтын байгууллагуудад өрнөж яваа, өрнөж байгаа энэ ил болж байгаа олон асуудлууд байна.

Бид Хүний эрхийн Комиссынхныг одоо бүрэлдэхүүнийг шинэчилсэн. Тэр үеэр бид бас одоо тодорхой асуудлуудаа тавьж юу ярьж байсан. Та нар тал тохой, танил тал тохой татдаг. Ялангуяа одоо нэг үеийн энэ их сургуулийн хуулийн одоо төгсөгч нар, шүүгч, прокурор нь нэг ангийнхан, өмгөөлөгч нар нь нэг ангийнхан, хүний комиссынхон, Хүний эрхийн Комиссынх нь нэг ангийнхан. Одоо хүний эрхийг хамгаалагчийн хорооны хороо байгуулна гэж ярьж байна. Энэ талаараа нэг жаахан тодруулж өгөөч. Тэгээд жишээлбэл энэ хүнд, Хүний эрхийн хорооны гишүүд маань одоо бас нэг талдаа гарчихсан ийм байх юм бол ер нь одоо хүний эрхийг хамгаалах тухай асуудал бол үнэхээр хүнд ийм байдал руу орно шүү. Би бол одоо энэ хүний эрхийг баталгаатай хамгаалах эрх эдлүүлэхтэй холбоотой. Би нэг минутаа авъя.

Г.Занданшатар: Нэмчихлээ, явж байна.

Б.Бат-Эрдэнэ: Энэ талд бол би олон жил одоо байр сууриа илэрхийлсэн. Одоо ч одоо тууштай байр сууриа илэрхийлж байгаа. Энэ орон нутагт одоо эрүүл аюулгүй орчинд хүн амьдрах ёстой. Энэ баталгааг нь хэн одоо хамгийн их зөрчиж байна вэ гэхээр зэрэг хууль бусаар одоо алт, уул уурхайн үйл ажиллагаа явуулж байгаа компаниуд зөрчиж байгаа. Цаашлах юм бол та бид бүгдээрээ мэдэж байгаа. Энэ төрийн хамгийн дээд өндөр албан тушаал, Ерөнхий сайдын алба хашиж байсан улсууд энэ төрийн нийтийн өмч хөрөнгийг завшаад зувчуулаад, зарим нь ял эдлээд, зарим нь одоо гадаадад зугтаж гараад, зарим нь одоо ажил асуудалтай холбогдоод ингээд явж байна шүү дээ. Тэгэхээр энэ чинь одоо нийт иргэдийн эрх ашгийг ноцтой хохироож байгаа асуудал мөн үү гэвэл мөн шүү дээ. Энэ дээр одоо ямар…/минут дуусав/

Г.Занданшатар: Мөнхцэцэг гишүүн ажлын хэсэгт Цэрэнжамцын Мөнхцэцэг гишүүн.

Ц.Мөнхцэцэг: Тэгэхээр Бат-Эрдэнэ гишүүний энэ хөндөн тавьсан

шийдэгдээгүй томоохон хэргүүд, тухайлбал энэ талийгаач Зориг агсны асуудал, дараа нь энэ иргэн Чимгээг мөрдөн эрүүдэн шүүсэн зэрэг асуудал маань үндсэндээ одоо Монгол Улсад эрүүдэн шүүх ийм ноцтой гэмт хэргийн зөрчил, ноцтой хүний эрхийн зөрчил байгаад байгаагийн бодит баталгаа. Харамсалтай нь энэ хэрэг шийдэгдэхгүй удаад байгаа энэ шалтгаан. Мөн энэ хэргийн талаар одоо дуугарсан зарим хүмүүс гэдэг юм уу, тухайн одоо хохирогчийн өмгөөлөгч нар зэрэг ийм хүмүүст бол хүний эрхийн болон одоо бусад аюулгүй байдлын хувьд бол аюул занал байгаад байгаа.

Тийм учраас энэ хууль маань энэ зөрчигдсөн эрх, хүний эрхийн төлөө зүтгэж явж байгаа хүмүүсийнхээ аюулгүй байдлыг хангах эрх зүйн баталгаа бий болгох эрсдэлийг нь одоо үнэлэх, тэгээд дээрээс нь одоо төр өөрийн хамгаалалтад авах ийм одоо зохицуулалт учраас бол цаашид энэ хүний эрхийн зөрчлийн эсрэг тэмцэгчид маань хүний эрхийг хамгаалагчид маань зоригтой дуугарч төрийн хамгаалалтад, мөн одоо тодорхой, одоо дэмжлэг бол явуулах болно. Тийм учраас энэ хууль бол өнгөрсөн, одоо жилүүдийн хүний эрхийн зөрчлийг багасгах, цаашид одоо хүний эрхийн ноцтой зөрчил гарахгүй байхын эсрэг ийм олон улсын том одоо механизм бас ийм шинэ хууль байгаа. Тэгээд хорооны одоо бүрэлдэхүүн буюу тухайн одоо хүний эрх хамгаалагчийг өмгөөлөн дэмжих энэ хорооны бүрэлдэхүүн иргэний нийгмийн байгууллагууд, Хуульчдын холбоо, Өмгөөлөгчдийн холбоо зэрэг гол одоо төлөөллүүдээс бүрдсэн нээлттэй сонгон шалгаруулалтаар орж ирнэ. Түүн дээр бол одоо Бат-Эрдэнэ гишүүний хэлсэн тэр ангийн болон одоо хамаатан садан, танил талын хэлхээ холбоог бол байлгахгүй байх, энэ талаар. Мөн одоо нээлттэй байх зарчмаар бүрдүүлнэ гэдгийг бол хуулийн одоо төсөлдөө суулгаж өгсөн байгаа.

Ер нь цаашид хараат бус механизм, хүний эрхийн хараат бус одоо комисс хүний эрхийн үндэсний тогтолцоо бол ингээд хараат бус зүгээр хуульд захирагдаж явах ёстой. Тэр одоо тогтолцоонд энэ хууль маань дэмжлэг үзүүлнэ гэдэгт бол итгэж байгаа ажлын хэсгийн алагчийн хувьд.

Г.Занданшатар: Баярлалаа. Мөнхөөгийн Оюунчимэг гишүүн асуулт асууна. Өнөөдөр хийж байгаа ингээд олон улсын байгууллагууд, манай Монголын судалгааны байгууллагууд, тэгээд хамгийн сүүлд Amnesty international, Хүний эрхийн Комиссын энэ судалгаануудыг харахад хүний эрхийг хамгаалагчдын талаар бид үнэхээр хууль эрх зүйн орчныг нь бүрдүүлээд ажиллах цаг бол хэдийнээ болсон гэдэг нь бол харагдаад байгаа юм. Хамгийн гол нь энийгээ бид зөв тайлбарлаж, иргэдэд зөв ойлгуулж чадахгүйгээс, ингээд буруу ойлголтууд энэ танхим дотор хүртэл сая явж байна шүү дээ. Би зүгээр гуравхан тод жишээг ярья гэж бодож байна л даа. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зарцуулагдах төсөв хөрөнгө ямар буруу замаар явж байгаа талаар одоо нэрт сэтгүүлч Болормаа дуугарч энэний төлөө тэмцэж байсан. Гэвч одоо ямар ч нэг шалтгаан нь өнөөдөр хүртэл тодорхойгүйгээр зүгээр л явж байгаад амь насаа алдсан. Нөгөө ирвэс хамгаалагч залуугийн тухай та бүхэн бүгд мэдэж байгаа байх. Бас л энэ бол эрхээ хамгаалж, тэр ажлаа хамгаалж дуугарч байсан, бас л үл мэдэх шалтгаанаар нас барсан. Одоо хамгийн сүүлд энэ Зоригийн хэрэг дээр тэр Чимгээ гээд тэр хүн буруу юм хийсэн хийгээгүйг бид мэдэхгүй. Гэхдээ эмэгтэй хүнийг эрүүдэн шүүж болохгүй. Энэ талаар одоо дуугарсан хүмүүсийг бас л нэр нүүрээ хаягаа нуусан хаягуудаас ингээд л төлбөртэй, зохион байгуулалттай дайралт, олон нийтийн сүлжээгээр чинь гээд л үнэхээр аймшгийн хэмжээнд явж байгаа байхгүй юу.

Тэгэхээр энэ юу яриад байна гэхээр энэ хүний эрхийг хамгаалагчдын, бас

шударга бус юмны төлөө зоригтой дуугарч байгаа тэр амьтны эрхийг хамгаалж байгаа хүмүүсийн хүртэл эрх ашгийг хамгаалах эрх зүйн орчин зайлшгүй хэрэгтэй байгааг энэ явдлууд харагдаад байна л даа. Тийм учраас түрүүн Их Хурлын даргын хэлээд байгаа тэр иргэний нийгмийн оролцоо, тэдний орон зай, үйл ажиллагаа бол үнэхээр чухал, шударга дуу хоолой. Гэтэл сүүлийн жилүүдэд манай иргэний нийгэм яг энэ түвшинд бас ажиллаж чадахаа байчихсан. Сая хэлж байна л даа. Үйлдвэрчний эвлэл гээд. Үйлдвэрчний эвлэл ч гэсэн бараг л зохион байгуулалттай ингээд болчхоод байна. Үнэхээр дуугарсан дуу хоолой тэр орон зай нь нөлөөлж чадахгүй энэ түвшинд хүрчхээд байгаа учраас Улсын Их Хурал энэ хүний эрх хамгаалахтай холбоотой хуулийг бол гаргах ёстой гэж би бодож байгаа. Харин энэ зүгээр саяын хэлээд байгаа зүгээр тунхаглал чанарын заалтууд ороод энэ бол амьдралд ийм хүнд хүнд кэйсүүд хэрэгжиж чадахгүй.

Г.Занданшатар: Оюунчимэг гишүүн нэг минут.

М.Оюунчимэг: Би тэгээд энд байгаа Хүний эрхийн Комиссынхноос асууя гэж бодоод байгаа юм. Та нар энд яг тэр бодит амьдрал дээр хэрэгжээд, тэр иргэний нийгмийн орон зайг нь бий болгоод, яг хүний эрхийг аливаа амьтны эрхийг хамгаалж дуугарч байгаа байгаль орчныг хамгаалж дуугарч байгаа хүмүүсийг яг бодитоор хамгаалах, тэр суурь дэд бүтэц, уур амьсгалыг бүрдүүлэх тал дээр тодорхой заалт орсон юм уу? Энэ дээр та бүхэн энэ хууль хийсэн хүмүүстэй хамтарч ажиллав уу? Би та бүхэнд бас манай Байнгын хороон дээр тайлан тавихад маш их яриад байгаа шүү дээ, нэг заалт хийх өөр. Гэтэл бодит амьдрал дээр энийг шууд хэрэгжүүлээд байдаг тэр хэрэгжих механизмыг нь бүрдүүлэх тал дээр та бүхэн сайн ажиллаач гэж би та нарыг бас сонгосон. Тэгээд энэ дээр ямар заалт орсон бэ, яавал энэ бодит амьдрал дээр хэрэгжих вэ гэдэг дээр надад нэг тодорхой хариулт өгөөч гэж хэлмээр байна.

Г.Занданшатар: Мөнхцэцэг гишүүн Цэрэнжамцын Мөнхцэцэг гишүүн.

Ц.Мөнхцэцэг: Тэгэхээр Оюунчимэг гишүүний дурдсан энэ одоо өнгөрсөн, энэ одоо харамсалтай тохиолдлууд сэтгүүлч Болормаа болон одоо ирвэс хамгаалагч Лхагвацэрэнгийн асуудал бол үнэхээр Монгол Улсад бас хүний эрхийн төлөө тэмцэгчдэд аюул занал бодитоор байгаа гэдэг илэрхийлэл. Олон улсын түвшиндээ ч гэсэн энэ тохиолдол бол хүний эрхийн хамгаалах механизм дээр заавал одоо энэ үндэсний хүний эрх хамгаалагчийн тогтолцоог бол оруулж ирдэг ийм одоо олон улсын жишиг байгаа. Тэгээд цаашид одоо энэ чиглэлээр одоо дуугарах хүмүүс илүү нэмэгдэнэ. Ер нь бол байгаль орчин, уул уурхайтай холбоотойгоор орон нутагт, мөн одоо хүний эрхийн бусад зүтгэлтнүүд, тухайн одоо дунд сургуулийн орчин ч гэдэг юм уу ерөөсөө бүх шатандаа хүний эрхийн төлөө дуугарч байгаа хүмүүсээ хамгаалах, тэд нар маань одоо хуульд заасан үндэслэлээр тайван замаар, хүчирхийллийн бус аргаар, хуулийн дагуу хүний эрхээ хамгаалж байгаа тохиолдолд энэ хуулийн ивээл өмгөөлөлд бол багтана.

Тэгээд хүний эрхийн хороо маань энэ комисстойгоо цуг ажиллана. Комисс бол өнөөдөр бол ингээд таван хүний бүрэлдэхүүнтэй. Монгол Улсын бас одоо бүх өргөн уудам газар нутаг, тухайн одоо холын хүний эрхийн зөрчил болгонд хүрч ажиллах бол ийм бас хүн хүчний болон бусад боломж бол хомс юм байна. Тийм учраас одоо хүний эрхийн энэ хамгаалагчийн хороо бол тэр орон нутагт байгаа иргэдийн өөрсдийнх нь одоо хүний эрхийн дуу хоолой болж, өөрсдийнх нь одоо хүч хүрэхгүй газар иргэд маань тэнцүү тэмцэж явах учраас энэ хууль бол ингээд тодорхой хэмжээгээр үндэсний одоо хүний эрхийн тогтолцоогоо дэмжих томоохон

одоо дэмжлэг болно гэдэгт бол бид нар одоо итгэлтэй байгаа. Тэгээд манай Хүний эрхийн Комиссын гишүүд бас нэмж хариулт өгөх байх.

Г.Занданшатар: Жамъянхорлоогийн Сүхбаатар гишүүн ажлын хэсгийн гишүүн бас нэмж хариулъя гэсэн.

Ж.Сүхбаатар: Баярлалаа, нэлээн удаан хүлээсний эцэст л хариулах боломж олдлоо. Үгүй ээ, энд нэг асуудал байгаад байгаа юм. Гишүүд бас нэг зүйлийн ялгаа байна. Энэ бол хүний эрхийн тухай одоо шууд хууль бас биш байгаа. Хүний эрх хамгаалагчийн эрхийг хамгаалах тухай хууль байхгүй юу. Хүний эрх хамгаалагчийн эрхийг хамгаална. Тэгэхээр энэ юу гэсэн үг юм бэ гэхээр Хүний эрхийн Үндэсний Комиссын үүрэг бол хүний эрхийг хамгаалах гээд бүтнээрээ их том чиг үүрэг байгаа. Энэ нь дотроос нь ер нь хүний эрхийг хамгаалах ажлыг хамгийн гардан гүйцэтгэдэг идэвхтэй энэ хамгаалагчдынхаа эрхийг тусгайлан хамгаалах чиг үүргийг Хүний эрхийн Үндэсний Комиссын хажууд, хүний эрх хамгаалагчийн хороо гээд, тэгээд тэр нь бол дөрвөн хүн, долоон хүний чинь нэг нь бол Хүний эрхийн Комиссын гишүүн ахлах юм. Тэгээд дөрвийг нь болохоор иргэний нийгмийн, яг энэ чиглэлийн хүмүүсийг оролцуулаад төр иргэний нийгмийн түншлэлээр яг хүний эрхийг хамгаалагчдынхаа тусгайлан хамгаалах энэ чиг үүргийг хэрэгжүүлье. Энэ нь бол Хүний эрхийн Үндэсний Комиссын нэг том чиг үүргийг тусгайлан дэмжиж тэндээ дүгнэлт гаргадаг, гомдол мэдээллийн дүн шинжилгээ хийдэг ийм юм байх юм байна лээ.

Би эхний үед бол зарим гишүүдтэй адилхан жоохон шүүмжлээд байсан. Цогтбаатар гишүүн нарын одоо хууль санаачлагч, тэгээд энэ Мөнхцэцэг гишүүн энэ гаднын одоо улсууд эд нарын юмыг хараад бас жоохон бодлоо өөрчилсөн. Хүний эрхийн хамгаалалт гэдэг бол Хүний эрхийн Үндэсний комиссын ажил биш. Их Хурлын одоо хамгийн гол ажил бол Үндсэн хуулийг хэрэглэх, хүний эрхийг хамгаалах. Тийм учраас Улсын Их Хурлын дарга хүний эрх, ардчиллын чуулган байх болно гэж хэлдэг чинь ерөөсөө бид нарын эрхэм зорилго байгаа байхгүй юу. Энэ дотроо хамгийн чухал хүмүүс нь тэр хүний эрх хамгаалдаг хүмүүсийн эрхийг хамгаалах ажил орхигдчихсон юм байна лээ. Шүгэл үлээгчийн тухай хууль гээд бас л энэ чинь нэг талын нэмэлт механизм. Хүний эрх хамгаалагч их олон чиглэлээр их тийм хоосон онгорхой зайнууд байна л даа. Тэр болгоны нэмэлт баталгаагаар нэмэлт, үйл ажиллагааг нь ингэж хангаж өгөх ажлыг дэмжиж өгч байж сая явна. Энэ бол ганцхан төрийн ажил байдал орох гэж байгаа асуудал биш. Энэ дээр бол иргэний нийгмийн улсууд, энэ хүний эрх хамгаалагчийн хороонд ажиллах энэ Хүний эрхийн Үндэсний Комисстой туслах юм байна лээ шүү. Тэгээд энийг би л нэмж бас хэлэх гэсэн юм энэ улсуудад.

Г.Занданшатар: Баярлалаа. Хүний эрхийн Үндэсний Комисс наян зургаа Энхболд.

Б.Энхболд: Та бүхэнд өглөөний мэнд хүргэе. Тэгээд энэ хүний эрхийг хамгаалагчийн асуудлаар үнэхээр одоо анхаарал хандуулж байгаад бол хэлэлцэж, энэ хуулийн төслийг одоо дэмжиж байгаад одоо Хүний эрхийн үндэсний байгууллагын хувьд бол их талархалтай хандаж байгаа. Тэгээд Оюунчимэг гишүүний асуулт бол маш чухал асуудал, асуулт. Мөн сая Сүхбаатар гишүүн бас хэллээ. Тэгэхээр энэ хуулийн гол зорилго нь бол хүний эрхийг хамгаалж аваад, өөрөөр хэлбэл тодорхой нийтийн эрх ашгийг хамгаалж аваад эрсдэлд орчихсон хүнийг хэрхэн хамгаалах вэ гэдэг агуулга байгаа юм. Тэгэхээр энэ хуулиар бол яг тэр хороо бол хүний эрхийг хамгаалж яваад эрсдэлд орсон байна гэдгийг нь

тогтоочхож байгаа юм. Одоо энэнээс цаашаа тэр хамгаалалт нь ямар хэлбэрээр яаж явах вэ гэдэг бас хэд хэдэн процессын одоо заалтуудыг энэ хуульд бол зайлшгүй тусгаж өгөх шаардлага бол байгаа гэж Хүний эрхийн Үндэсний Комисс үзэж байгаа.

Одоо бол Гэрч хохирогчийг хамгаалах тухай хуультай уялдуулаад ингээд тодорхой заалтуудыг оруулчихсан байгаа. Гэсэн хэдий ч энэ олон улсын одоо загвар хууль бусад одоо хуулиудаас харахад бол яг эрсдэлд орчихсон байгаа хүнийг бол нэг цагийн дотор энийг яах юм. Цаашилбал одоо аль байгууллагад холбон зуучилж хамгаалалтад авах юм. Тэр хүнд учирсан хохирлыг буцааж яаж нөхөн төлүүлэх вэ гэдэг энэ механизмуудыг энэ хууль руу илүү дэлгэрүүлж оруулж өгвөл илүү одоо үр нөлөөтэй амьд, тэр хүний эрхийг хангаж хамгаалах чиглэлд одоо ахиц дэвшил гарна гэж ингэж үзэж байгаа юм. Энэ хуулийн гол ач холбогдол нь юу вэ гэхээр өнөөдөр Хүний эрхийн Үндэсний Комисс нэгдүгээрт гомдол хүлээж авч байна, хоёрдугаарт хяналт шалгалт хийж байгаа, гуравдугаарт урьдчилан сэргийлэхийг бол ингээд сургалт, соён гэгээрүүлэх гээд хийгээд байдаг.

Гэтэл бид бүхний огт мэдэхгүй энд тэндээс гэнэт, гэнэт хүний эрхийн зөрчил гараад ирэхээр комисс бол яах аргагүй шүүмжлэлд өртөөд байгаа ийм асуудал байдаг. Тэгэхээр энэ бүх асуудлуудыг хяналтдаа авч, мэдээлэл авч хамтран ажиллахад бол энэ хүний эрхийн төлөө тэмцдэг энэ олон идэвхтнүүдийг бий болгох, тэдгээрийн хамгаалалтыг бол баталгаатай болгох зайлшгүй шаардлага байгаа учраас…/минут дуусав/

Г.Занданшатар: Гишүүд асуулт асууж хариулт авч дууслаа. Одоо санал хураалт явна. Байнгын хорооноос гаргасан зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураана. Цахим санал хураалтад бэлтгэнэ үү? Зарчмын зөрүүтэй гучин хоёр санал байгаа. Болно, болно. Гучин хоёр санал байгаа. Төхөөрөмжүүдээ бэлдээд санал хураалтад бэлтгэнэ үү? Эхлээд бүртгэлийн санал хураалт, IPad-уудыг бүртгэлд хамруулна. Санал хураалтад оролцож байгаа гишүүд санал хураалтад оролцохдоо гишүүд myparliament программыг ашиглана, ipad төхөөрөмжийнхөө wifi-г унтраагаад, 3G sim картаар орсон байх шаардлагатай. Санал өгөхдөө myparliament программд орж зүүн дээд буланд байрлах онлайн санал хураалт гэсэн цэс рүү нэвтэрч чуулганы нэгдсэн хуралдаан гэсэн сонголтыг сонгоно. Бүртгэлийн санал хураалт явуулъя. Алтанхуяг, Амарсайхан, Анандбазар, Анужин, Баттөмөр, Баярсайхан, Булгантуяа, Бямбацогт, Ж.Ганбаатар, Ганибал, Ганхуяг, Даваасүрэн, Дамдинням, Жаргалмаа, Мөнх-Оргил, Мөнхцэцэг, Оюунчимэг, Пүрэвдорж, Сарангэрэл, Саранчимэг, Тогтохсүрэн, Ундрам, Цогтбаатар, Цогтгэрэл, Чинзориг, Энх-Амгалан, Өнөрболор нарын гишүүд бүртгэлд орж ирээгүй байна. Саяын нэр дурдсан гишүүд ipad аа бүртгэлд оруулна. Түрүүн Пүрэвдорж гишүүн байсан яасан бэ? Манай энэ Ардчилсан намын бүлгийн гишүүд бол энэ хүний эрхийн асуудлыг хамгийн сайн дэмжих ёстой юм байгаа юм. Яагаад ирц муу байна вэ? Энэ цахим дээр бүгд байхгүй байгаад байна. Саяын бүртгэлд ороогүй гишүүдийнхийг бүртгүүлнэ үү.

Туршилтын санал хураалт. 61 гишүүний ирцтэй байж байна. 33 гишүүн дэмжиж байна. Адьшаа гишүүнээ, Ганбат гишүүн, Адъяасүрэн гишүүн, Пүрэвдорж гишүүн танайхан бүгд ингэж тэр бүртгэлд, Ганибал бүгд эсрэг гараад байна шүү. Ер нь цахим дээр. Бямбацогт гишүүнийх ирсэн үү. Мөнхцэцэг гишүүнийх гарсан уу? Санал хураалт. Цогтбаатар хууль санаачлагч ирлээ. Эхэлье.

Хүний эрх хамгаалагчийн эрх зүйн байдлын тухай хуулийн төслийн талаарх

зарчмын зөрүүтэй саналын томьёоллын Хууль зүйн байнгын хороо дэмжсэн саналуудаар санал хураалт явуулъя.

1.Төслийн 1 дүгээр зүйлийн 1.1 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“1.1.Энэ хуулийн зорилт нь хүний эрх хамгаалагчийн эрх зүйн байдлыг тодорхойлох, хөхиүлэн дэмжих, хүндэтгэх, хамгаалах, үйл ажиллагаа явуулах нөхцөлөөр хангах, хамтран ажиллах, Хүний эрх хамгаалагчийн хорооны бүтэц, зохион байгуулалт, үйл ажиллагаатай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.” Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Цэрэнжамцын Мөнхцэцэг, Салдангийн Одонтуяа, Цэндийн Сандаг-Очир, Жамъянхорлоогийн Сүхбаатар, Баттөмөрийн Энхбаяр цаашид ажлын хэсэг гэнэ. Санал хураалт. Санал хураалтад 61 гишүүн оролцож 41 гишүүн дэмжиж 67,2 хувийн саналаар санал дэмжигдлээ.

2.Төслийн 2 дугаар зүйлийн 2.1 дэх хэсгийн “Үндсэн хууль,” гэсний дараа “Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хууль,” гэж нэмж, 3 дугаар зүйлийн 3.1 дэх хэсгийн “нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа” гэснийг “нутаг дэвсгэрт хүний эрх хамгаалах үйл ажиллагаа явуулсан, явуулж байгаа” гэж, “тодорхойлно” гэснийг “зохицуулна” гэж өөрчлөх, санал гаргасан ажлын хэсэг, Санал хураалт. Санал хураалтад 61 гишүүн оролцож 38 гишүүн дэмжиж 62,3 хувийн саналаар санал дэмжигдлээ.

3.Төслийн 3 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 3.2 дахь хэсгийг нэмэх:

“3.2.Гадаад улсын нутаг дэвсгэрт хүний эрх хамгаалах үйл ажиллагаа явуулсан Монгол Улсын иргэний эрх зүйн байдлыг Монгол Улсын олон улсын гэрээний дагуу зохицуулна.” санал гаргасан ажлын хэсэг, Санал хураалт. Санал хураалтад 61 гишүүн оролцож 38 гишүүн дэмжиж 63,2 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

4.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 4 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“4 дүгээр зүйл.Хуулийн нэр томьёоны тодорхойлолт

4.1.Энэ хуульд хэрэглэсэн дараах нэр томьёог доор дурдсан утгаар ойлгоно:

4.1.1“хүний эрх хамгаалагч” гэж ганцаараа, эсхүл бусадтай эвлэлдэн нэгдэж, хүний эрх хамгаалах үйл ажиллагаа явуулж байгаа, түүнд оролцож байгаа хүнийг;

4.1.2.“хүний эрх хамгаалах үйл ажиллагаа” гэж хүний эрх, эрх чөлөөг хөхиүлэн дэмжиж, хүний эрх, эрх чөлөөг зөрчсөн үйлдэл, эс үйлдэхүйн эсрэг хүчирхийллийн бус, тайван аргаар үзэл бодлоо илэрхийлж, олон улсын эрх зүйн нийтээр хүлээн зөвшөөрсөн хэм хэмжээ, зарчмыг хүндэтгэж, хүний эрхийг хамгаалах;

4.1.3.“хүний эрх хамгаалагчийн эрхийг хамгаалах” гэж төр, хүн, хуулийн этгээд, тодорхой ашиг сонирхлоор нэгдсэн аливаа этгээдийн зүгээс хүний эрх хамгаалагчийн эрх, эрх чөлөөг зөрчихөөс урьдчилан сэргийлэх,

таслан зогсоох, зөрчигдсөн эрхийг сэргээн эдлүүлэх, учирсан хохирлыг нөхөн төлүүлэхэд чиглэгдсэн төрийн байгууллагын үүргийг;

4.1.4.“хүний эрх хамгаалагчийн эрхийг хүндэтгэх” гэж төрийн байгууллага хүн, хуулийн этгээд хүний эрх хамгаалагчийн хууль ёсны үйлдлийг таслан зогсоохгүй, саад учруулахгүй, эсхүл эрх, эрх чөлөөнд нь хууль бусаар халдахгүй байх үүргийг;

4.1.5.“хүний эрх хамгаалагчийн эрхийг зөрчих” гэж Хүний эрх хамгаалах үйл ажиллагаатай нь холбогдуулан хүний эрх хамгаалагчид болон түүний гэр бүлийн гишүүн, асран хамгаалагч, хамтран амьдрагч, төрлийн хүн, хууль ёсны төлөөлөгчийг аливаа хэлбэрээр доромжлох, гүтгэх, худал мэдээлэл тараах, ялгаварлан гадуурхах, үйл ажиллагааг нь дэмжихгүй байхыг уриалах, албадах, хүч хэрэглэх, хүч хэрэглэхээр заналхийлэх, мөрдөж мөшгөх, амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгөнд нь гэм хор учруулах үйлдэл, эс үйлдэхүйг;

4.1.6.“эрсдэлийн үнэлгээ” гэж хүний эрх хамгаалагчид болон түүний гэр бүлийн гишүүн, асран хамгаалагч, хамтран амьдрагч, төрлийн хүн, хууль ёсны төлөөлөгчид учирч буй аюул, эрсдэлийн түвшнийг тодорхойлсон дүгнэлтийг.” Санал гаргасан ажлын хэсэг. Энэ 4 дүгээр заалт дээр дэмжсэн дэмжээгүй үг хэлэх саналыг Лхагвын Мөнхбаатар гишүүн ирүүлсэн байна. Лхагвын Мөнхбаатар гишүүн цахимаар.

Л.Мөнхбаатар: Баярлалаа. Энэ зарчмын зөрүүтэй саналыг ингээд уншаад үзэхээр энэ 4.1.5-д байгаа хүний эрх хамгаалагчийн эрхийг зөрчих гэдэг нь бол энэ нэр томьёоныхоо хувьд тодорхойлолт нь өөрөө энэ хуулийн гол одоо заалт юм байна л даа. Ингэхээр энэ хүний эрхийн хамгаалагчийн эрх зөрчигдөх энэ тохиолдлуудыг энэ нэр томьёонд тусгаснаас гадна одоо хуулийнхаа одоо бусад зүйл заалтуудад нарийн тусгаж тайлбарласан зүйлүүд бас байхгүй байна. Энийгээ хэлэлцүүлгийг явцад анхаараарай гэдгийг хэлье. 2 дугаарт энэ хүний эрх хамгаалагчийн эрхийг зөрчих гээд энэ 4.1.5-д байгаа энэ заалт болохоороо хүний эрх хамгаалах үйл ажиллагаатай холбогдуулан хүний эрхийг хамгаалагчид болон түүний гэр бүлийн гишүүн асран хамгаалагч хамтран амьдрагч төрлийн хүн, хууль ёсны төлөөлөгч гээд эдгээр хүмүүсийг аливаа хэлбэрээр доромжлох гүтгэх худал мэдээлэл тараах ялгаварлан гадуурхах үйл ажиллагааг нь дэмжихгүй байхыг уриалах гэх мэт энэ зүйлүүдээр одоо гэр хор учруулах, эс үйлдэхүйг үйлдэл болон үйлдэхүйг одоо ойлгоно гэсэн байгаа юм.

Хүний эрхийг хамгаалагч гэдэг маань өөрөө энэ хоёр ойлголт, хоёр зүйлийг агуулсан ойлголт байгаад шүү дээ. 1 дүгээрт нь тодорхойлолтоор бол хувь хүн ганцаараа байж болно. 2 дугаарт эсхүл бусадтай эвлэлдэн нэгдсэн этгээдийг ойлгохоор байгаа юм. Гэтэл одоо энэ саяын томьёоллыг уншаад үзэхээр нөгөө хүний эрх хамгаалах байгууллага нь энэ дээр орохгүй нь л дээ. Хүний эрх хамгаалах байгууллага. Тэгэхээр энийг бол тусгаж өгөхгүй бол уг нь зөвхөн одоо хувь хүн гэж ойлгоод явахаар байх нь. Тийм учраас энэ загвар хууль дээрээ ч гэсэн энэ хүнийг эрхийг хамгаалах байгууллагын эрхийг зөрчигчдөөс хамгаалах тухай асуудал энэ загвар хууль дээрээ байна лээ шүү дээ. Тийм учраас энэ зүйлээ оруулахгүй бол зөвхөн одоо хязгаарлагдмал зөвхөн хүний эрхийг хамгаалагч хүний тухай асуудал яригдаад байх нь байна. Хүний эрх хамгаалагч байгууллагынхаа асуудлыг энэ дээр оруулж томьёолох нь зүйтэй гэдгийг хэлье.

Баярлалаа.

Г.Занданшатар: Эцсийн хэлэлцүүлэгт энэ саналыг анхааараарай. Хүний эрх хамгаалагч гэдэг дээр хувь хүнийг л заагаад байгаа л даа. Санал хураалт. Санал хураалтад 61 гишүүн оролцож 35 гишүүн дэмжиж 57,4 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ. 5 дугаар зүйл.

5.Төслийн 5 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“5 дугаар зүйл.Хүний эрх хамгаалагчийн үйл ажиллагааны үндсэн зарчим

5.1.Хүний эрх хамгаалагч үйл ажиллагаандаа дараах зарчмыг баримтална:

5.1.1.Үндсэн хууль, бусад хуулийг сахин биелүүлэх;

5.1.2.шударга, хүнлэг ёсыг эрхэмлэх;

5.1.3.авлига, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх;

5.1.4.ялгаварлан гадуурхахгүй байх;

5.1.5.бусдын нэр төр, алдар хүнд, эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хүндэтгэх.” Санал хураалт явуулъя. Санал хураалтад 63 гишүүн оролцож 37 гишүүн дэмжиж 58,7 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

6.Төслийн ХОЁРДУГААР БҮЛГИЙН гарчгийн “ХАМГААЛАГЧИЙН ЭРХ,” гэсний дараа “САНХҮҮЖИЛТ,” гэж нэмэх, санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. Санал хураалтад 63 гишүүн оролцож 33 гишүүн дэмжиж 52,4 хувийн саналаар санал дэмжигдлээ.

7.Төслийн 6 дугаар зүйлийн 6.1.1 дэх заалтын “хамгаалахад” гэснийг “хамгаалах үйл ажиллагаа явуулах, сайн дураар” гэж, 6.1.2 дахь заалтын “таниулах, тэдгээрийг” гэснийг “олон нийтэд таниулах,” гэж өөрчилж, төслийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“6.1.Хүний эрх хамгаалагч дараах бүрэн эрхтэй:” санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. Санал хураалтад 63 гишүүн оролцож 36 гишүүн дэмжиж 57,1 хувийн саналаар санал дэмжигдлээ.

8.Төслийн 6.1.5 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“6.1.5.хүний эрх хамгаалах үйл ажиллагаа явуулдаг үндэсний болон гадаад улсын, бүс нутгийн болон олон улсын байгууллагатай харилцах, хамтран ажиллах;” санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. Санал хураалтад 63 гишүүн оролцож 57 гишүүн дэмжиж 58,7 хувийн саналаар санал дэмжигдлээ.

9.Төслийн 6 дугаар зүйлийн 6.1.7 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“6.1.7.хуулийн дагуу нуцад хамааруулснаас бусад мэдээллийг хүний эрх, эрх чөлөөг хамгаалах зорилгоор төрийн байгууллага, хуулийн этгээдээс хуульд

заасан аргаар хайх, олж авах, хэвлэн нийтлэх, хадгалах, бусадтай хуваалцах;” санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. Санал хураалтад 63 гишүүн оролцож 39 гишүүн дэмжиж 61,9 хувийн саналаар санал дэмжигдлээ.

10.Төслийн 6 дугаар зүйлийн 6.1.9 дэх заалтын “үүнийгээ хүлээн зөвшөөрүүлэхэд нөлөөлөх,” гэснийг, 6.1.10 дахь заалтын “төрийн үйл хэрэгт оролцох,”, “шүүмжлэх,”, “зөвлөмж хүргүүлэх,” гэснийг, 6.1.13 дахь заалтын “хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа” гэснийг, мөн зүйлийн 6.1.4, 6.1.14, 6.1.15, 6.1.18 дахь заалтыг хасах санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. Санал хураалтад 63 гишүүн оролцож 37 гишүүн дэмжиж 58,7 хувийн саналаар санал дэмжигдлээ.

11.Төслийн 6 дугаар зүйлийн 6.1.6, 6.1.16 дахь заалтыг хасах санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. Санал хураалтад 63 гишүүн оролцож 40 гишүүн дэмжиж 63,5 хувийн саналаар санал дэмжигдлээ.

12.Төслийн 6 дугаар зүйлийн 6.1.11 дэх заалтын “этгээдийн” гэсний дараа “бичгээр гаргасан” гэж, 6.1.12 дахь заалтын “үйлдлийн талаар” гэсний дараа “холбогдох олон улсын гэрээнд заасан журмын дагуу” гэж нэмж, 6.1.13 дахь заалтын “олон улсын холбогдох хэм хэмжээг” гэснийг “Монгол Улсын олон улсын гэрээг” гэж, 6.1.17 дахь заалтын “сэтгэл санааны болон бодит хохирлоо” гэснийг “эдийн болон эдийн бус хохирлоо хуульд заасан журмын дагуу” гэж өөрчлөх санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. Санал хураалтад 63 гишүүн оролцож 38 гишүүн дэмжиж 60,3 хувийн саналаар санал дэмжигдлээ.

13.Төсөлд доор дурдсан агуулгатай 7 дугаар зүйл нэмэх:

“7 дугаар зүйл.Хүний эрх хамгаалагчийн үйл ажиллагааны санхүүгийн ил тод нээлттэй байдал.

7.1.Хүний эрх хамгаалагчийн үйл ажиллагаа явуулахтай холбогдсон аливаа санхүүгийн нөөц, эх үүсвэр ил тод, нээлттэй байх бөгөөд санхүүгийн нөөц дараах эх үүсвэрээс бүрдэнэ:

7.1.1.хуульд өөрөөр заагаагүй бол хүн, хуулийн этгээдээс өгсөн хандив, тусламж;

7.1.2.хуульд заасны дагуу төрөөс үзүүлсэн мөнгөн болон бусад хэлбэрийн санхүүгийн дэмжлэг;

7.1.3.хууль тогтоомжоор хориглоогүй бусад эх үүсвэр.

7.2.Хүний эрх хамгаалагчийн үйл ажиллагааны санхүүжилтэд дараах нөөц, эх үүсвэрийг хориглоно:

7.2.1.гадаад улсын тусгай албад, түүний халхавч байгууллага болон үндэсний эв нэгдлийг бусниулах, мөнгө угаах, террорист болон экстремист үйл ажиллагаа явуулдаг, санхүүжүүлдэг байгууллага, хувь хүнээс, эсхүл хандивлагч нь тодорхойгүй санхүүжилт авахыг хориглоно;

7.2.2.хуулиар зөвшөөрснөөс бусад аргаар санхүүгийн нөөц, эх үүсвэрийг хайх, хүлээн авах, захиран зарцуулахыг хориглоно.” санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. Энэ заалт их сайн бичсэн байна шүү ажлын хэсэг. Санал

хураалтад 63 гишүүн оролцож 37 гишүүн дэмжиж 58,7 хувийн саналаар санал дэмжигдлээ. Хуульд зөвшөөрснөөс бусад арга хэлбэрээр гэдэг юм уу тэгж эцсийн найруулга дээрээ та хэд бас анхааараарай. Санхүүжилт бол голдуу л хэлбэрүүд л байгаа байх. Санал хураалтад 63 гишүүн оролцож 37 гишүүн дэмжиж 58,7 хувийн саналаар санал дэмжигдлээ. За.

14.Төслийн 7 дугаар зүйлийн 7.1.1 дэх заалтын “арга” гэсний дараа “хэрэглэж” гэж нэмж, мөн зүйлийн 7.1.2 дахь заалтын “алдар хүнд, нэр төрийг” гэснийг “үйл ажиллагааг” гэж, 7.1.3 дахь заалтын “хүний эрх, эрх чөлөөг, үл хүндэтгэх, зөрчих” гэснийг “бусдын нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндийг гутаах" гэж өөрчлөх санал гаргасан ажлын хэсэг. Энэ дээр дэмжсэн дэмжээгүй Дамдины Цогтбаатар гишүүн үг хэлнэ.

Д.Цогтбаатар: Энэ өдрийн мэндийг хүргэе гишүүддээ. Яг энэ асуудал дээр даргаа нэг ийм асуудал байна. Ажлын хэсэг тэгээд энэ хууль санаачлагчийн хооронд бас нэг жаахан зохицож ойлголцох асуудал байгаа. Ялангуяа энэ хуулийг санал болгож байгаа төрийн бус байгууллагууд маань энэ дээр бас онцгой анхаарч үзээч. Яг хуулийн анхны үзэл баримтлалаас жаахан гажих гээд байна гэдэг асуудал яригдаж байгаа юм. Тийм учраас энийг энэ удаадаа санал хураалгахгүй үлдээж өгнө үү. Бид нар дараа нь энийгээ яриад эцэслээд орж ирье.

Г.Занданшатар: Ажлын хэсэг дэмжсэн, дэмжээгүй. Мөнхцэцэг гишүүн.

Ц.Мөнхцэцэг: Тэгэхээр энэ төслийн 7 дугаар зүйлийн 7.1.1, 7.1.2, 7.1.3 дээр бас яг энэ манай ажлын хэсэг хуралдаад шийдвэр гарсны дараа бас шинэ нөхцөл байдал үүссэн учраас энэ асуудлыг мөн буцаж аваад ажлын хэсэг дээр Байнгын хороон дээр хэлэлцэж оруулж ирье гэдэг Цогтбаатар гишүүний саналыг бол дэмжиж байна.

Г.Занданшатар: Энэ дээр хүний эрх, эрх чөлөөг гээд таслал тавьчихаар байна шүү дээ таслал бүхэн чинь бас утгыг алдагдуулна. Эрх чөлөөг гээд таслал тавьчхаад үл хүндэтгэх зөрчих гэснийг нэр төр алдар хүнд, ажил хэргийн нэр хүндийг гутаах гэж өөрчлөх. Алдар хүнд, нэр төрийг гэж нөгөө юунд Үндсэн хуульд бол тэгж байдаг л юм л даа. Энийг ингээд гүйцээн боловсруулах эцсийн хэлэлцүүлэг дээрээ Байнгын хороон дээрээ Бямбацогт дарга анхааръя. Гэхдээ энийг бол дордуулахгүй байх зарчим баримтлах юм байна. Ингээд санал хураахгүй. Дараагийн асуудал руу оруулъя. Гүйцээн боловсруулах чиглэл өгч байна.

15.Төслийн Гуравдугаар бүлгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“ГУРАВДУГААР БҮЛЭГ ТӨРИЙН БАЙГУУЛЛАГА, АЛБАН ТУШААЛТАН, ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН НИЙТЛЭГ ҮҮРЭГ

8 дугаар зүйл.Нийтлэг үүрэг

8.1.Төрийн байгууллага, албан тушаалтан, хуулийн этгээд хүний эрх хамгаалагчийн үйл ажиллагаанд дараах нийтлэг үүргийг хүлээнэ:

8.1.1.хүний эрх хамгаалагчийн эрхийг хүлээн зөвшөөрөх, зөрчихгүй байх;

8.1.2.үйл ажиллагаанд нь хүндэтгэлтэй хандах;

8.1.3.хүчирхийллийн бус, тайван аргаар үйл ажиллагаа явуулах боломж бүрдүүлэх;

8.1.4.шаардлагатай мэдээллээр хангах;

8.1.5.хуульд заасан үндэслэлгүйгээр хүний эрх хамгаалагчид аливаа хэлбэрээр халдахгүй байх;

8.1.6.хүний эрх хамгаалагчийн үйлдлийг хамгаалах зохицуулалтыг байгууллагын дотоод журамд тусгаж, хэрэгжүүлэх, сургалт зохион байгуулах;

8.1.7.хүний эрх хамгаалагчид халдсан тухай мэдээлэл, гомдлыг шийдвэрлэсэн хариуг бичгээр гомдол гаргагчид болон Хүний эрх хамгаалагчийн хороонд хүргүүлэх.

8.2.Цагдаагийн байгууллага хүний эрх хамгаалагчид халдсан халдлагыг таслан зогсоох, түүнийг өөрийнх нь зөвшөөрснөөр эсхүл энэ хуулийн 11.7-д заасан эрсдэлийн үнэлгээний дүгнэлтийг үндэслэн Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуульд заасан журмын дагуу хамгаалалтад авна.

8.3.Хүний эрх хамгаалагчийн эрх зөрчигдсөн тохиолдолд хуулиар хариуцсан чиг үүргийн хүрээнд шаардлагатай арга хэмжээг шуурхай авч хэрэгжүүлнэ.” санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. Санал хураалтад 63 гишүүн оролцож 37 гишүүн дэмжиж 58,7 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

16.Төслийн 10 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“10 дугаар зүйл.Хүний эрх хамгаалагчийн хороо

10.1.Хүний эрхийн Үндэсний Комиссын /цаашид “Комисс” гэх/ дэргэд хүний эрх хамгаалагчийн эрх зөрчигдсөн эсэх талаар дүгнэлт гаргах чиг үүрэг бүхий орон тооны бус Хүний эрх хамгаалагчийн хороо /цаашид “Хороо” гэх/ ажиллана.

10.2.Комиссын Хүний эрх хамгаалагчийн асуудал эрхэлсэн гишүүн Хорооны дарга байх бөгөөд Хорооны үйл ажиллагааг нэгдсэн зохион байгуулалтаар хангаж ажиллана.

10.3.Хороо үйл ажиллагаагаа бие даан явуулах бөгөөд дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

10.3.1.хүний эрх хамгаалагчийн эрх зөрчигдсөн талаарх гомдол, мэдээллийг хүлээн авах;

10.3.2.гомдол мэдээллийн талаар нотолгоо, баримт, мэдээлэл цуглуулах;

10.3.3.хүний эрх хамгаалагчийг хамгаалах хэрэгцээ шаардлагыг тодорхойлох, энэ хуулийн 11.7-д заасан эрсдэлийн үнэлгээ хийх;

10.3.4.эрсдэлийн үнэлгээнд үндэслэн гаргасан дүгнэлтийг Комисст хүргүүлэх;

10.3.5.энэ хуулийн хэрэгжилт болон хүний эрхийн хамгаалагчийн нөхцөл байдалд хяналт шинжилгээ, судалгаа хийж, жил бүр Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх илтгэлд тусгуулах;

10.3.6.гомдол, мэдээллийн сан бүрдүүлэх.

10.4.Хороо нь энэ хуулийн 10.2-т заасан даргаас гадна зургаан гишүүний бүрэлдэхүүнтэй байх бөгөөд энэ хуулийн 11.3-т заасан хоёр нэр дэвшигчийг шууд, бусад дөрвөн гишүүнийг ашгийн төлөө бус хуулийн этгээдийн төлөөллөөс нэр дэвшүүлэн, нээлттэй сонсголоор сонгон шалгаруулж, Комисс батламжилна.

10.5.Хорооны бүрэлдэхүүнийг томилохдоо жендэрийн тэнцвэртэй байдал болон үндэсний хэмжээнд идэвхтэй үйл ажиллагаа явуулж буй хүний эрх хамгаалагчийн олон талт төлөөллийг хангана.

10.6.Хорооны гишүүн үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, үг хэлэх, хэвлэн нийтлэх, шашин шүтэх, эс шүтэх эрх, эрх чөлөөгөө эдлэхдээ өөрийн албан тушаалд хүндэтгэлтэй хандана.

10.7.Хорооны гишүүн улс төрийн намын гишүүнчлэлээс түдгэлзэнэ.

10.8.Хорооны үйл ажиллагааны урсгал зардлыг Комиссын төсөвт тусгах бөгөөд Хорооны гишүүнд урамшуулал олгох журмыг Комисс батална.

10.9.Хорооны ажиллах журмыг Комисс батална.” Аюурсайхан гишүүн. Төмөрбаатарын Аюурсайхан гишүүн үг хэлнэ.

Т.Аюурсайхан: Энэ хуулийг хэлэлцэх эсэхийг ярьж байхад их олон гишүүд хэлэлцэх эсэхийг нь хэлэлцэхийг дэмжиж байна. Гэхдээ энэ хүний эрх хамгаалагчийн хороо гэж байх шаардлагагүй гэж маш олон гишүүд бас үгээ хэлж байсан шүү. Тэгээд үндэсний комисс энэ ажлыг хийх боломжтой дээр нь энэ бид нар Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийг шинэчилж найруулсан. Энэ дээр иргэний нийгмийн зөвлөл гэж бас байгуулж өгсөн байгаа. Комисс үйл ажиллагаагаа явуулахад дэмжлэг үзүүлэх чиг үүрэг бүхий иргэний нийгмийн зөвлөлтэй байна гээд. Энийг нь илүү сайн тодорхойлоод хүрээг нь тэлээд энэ иргэний нийгмийн зөвлөл дээрээ энэ чиг үүргийг нь аваад явах бүрэн боломжтой байсан.

Гэтэл эрх хамгаалагчийн хороо гэж давхар нэг бүтэц байгуулаад ингээд одоо ажлыг бас тодорхойгүй бие биен рүүгээ чиҳдэг ийм нөхцөл байдал үүсэж байгаа байхгүй юу. Бид нар Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийг шинэчилсэн найруулгыг хийсэн байгаа юм. Тэнд энэ Хүний эрхийн Үндэсний Комисст улс төрийн баталгаа, эдийн засаг, нийгмийн баталгаа, хууль зүйн баталгаа, аюулгүй байдлын баталгаа гээд 4 том баталгааг хуулиар олгоод өгсөн байгаа. Төсвийг бас тодорхой байдлаар Их Хурал дээрээс шийдэж өгч байгаа. Үндэсний комиссын гишүүдийг төрийн өндөр албан тушаалтанд бас тооцож байгаа. Ажиллах бүх нөхцөл боломжийг чинь төрөөс хангаж өгч байгаа. Тэгээд сонгон шалгаруулсан. Одоо ингээд 2 нөхөр ирсэн сууж байна. Сонгон шалгаруулахдаа та нар энэ ажлыг ёстой чадаад өгнө, мэдэж байгаа хийгээд өгнө

болно, бүтнэ гэж хэлж байгаад амлалт үүрэг авсан. Тэгээд дараа нь яасан бэ гэхээр одоо ингэж хүч чадал хүрэхгүй байна. Дахиж ийм хүн хүчээ нэмэх шаардлагатай. Иргэдийг татаж оролцуулах хэрэгтэй. Төрийн бус байгууллагыг татаж оролцуулахгүй бол ажлаа хийхэд бас хүндрэлтэй байна гээд энэ хуулийг оруулж ирж байгаа шүү дээ.

Тэгээд би бас сануулж байгаа юм. Одоо ингээд хуулийг бид нар явуулж байна, хэлэлцэж байна, ингээд батлах гэж байна. Тэгээд энэний дараагаар дахиад янз бүрийн юм ярихгүй шүү. Үндсэн ажлаа хийгээрэй. Хүний эрх алхам тутамд зөрчигдөж байгаа шүү. Үндсэн хуульд заасан түгээмэл эрхүүд. Одоо энэ хөл хорьж байгаа хязгаарлалтын дэглэм тогтоож байгаа энэ арга хэмжээнүүд Үндсэн хуульд заасан хүний үндсэн эрхэд харшилж болохгүй гээд энэ чинь хуулийн заалттай. Тэгээд амьд явах эрх эмнэлгийн тусламж үйлчилгээ авч чадахгүй байна. Тусгаарлалтад байгаа иргэдтэй харьцахгүй байна шүү дээ. Тусгаарлалтад байгаа иргэн нас барж байна шүү дээ. Түгээмэл одоо хоол хүнсээ хэрэглэж чадахгүй байна уу, эм авч чадахгүй байна уу, эрүүл мэндээ үзүүлж чадахгүй байна уу харьцахгүй. Гадаадаас ирсэн иргэд зочид буудлын цонхоор бууж байгаад нас барж байна. Энэ дээр ямар ажил хийж байгаа юм. Тэр гарцаагүй байдлаас болж байна уу, ямар нөхцөл байдалтай байсан юм. Тэр хүмүүстэй холбогдох хүмүүс харьцаж асуудлыг нь сонсож байх хэрэгтэй.

Тухай бүр нь шийдэж байх хэрэгтэй. Гэх мэтийн удаа дараа сануулж байгаа шүү. Энэ дээрээс болоод. Та дуугүй байдаг, ажлаа хийдэггүй. Тэгээд энэ дээр бол удаа дараа хатуу сануулж байгаа шүү ажлаа хийнэ шүү.

Г.Занданшатар: Хүний эрхийн Үндэсний Комисс ажлаа сайн хийх ёстой шүү. Айсан, дүрэм журам ярьсан байдлаар хүний эрхийг хамгаалахгүй л дээ. Ингээд Аюурсайхан гишүүний анхааруулгыг шаардлагыг анхаарч ажиллаарай Хүний эрхийн Комисс. Одоо Жаргалмаа гишүүн цахимаар үг хэлнэ.

Б.Жаргалмаа: Та бүхнийхээ өдрийн амгаланг айлтгая. Энэ хууль нь хүний эрхийн үндэсний тогтолцоог бэхжүүлэх, улам боловсронгуй болгоход чиглэгдэж байгаа. Гэвч яригдаж байгаа асуудал зохицуулалтын хувилбар одоогийн механизмыг хараат бус байдалд эрсдэлд учруулж болзошгүй байна гэж үзэж байна. Өөрөөр хэлэх юм бол бид нар Хүний эрхийн Үндэсний Комиссынхоо гишүүдийг томилоод удаагүй байгаа, үр дүнг нь ч гэсэн харах, үр дүн гарах хараахан болоогүй байгаа гэж үзэж байгаа.

Гэтэл хүний эрхийн үндэсний тогтолцоог бэхжүүлэх боловсронгуй болгох энэ ажил маань хүн нэмснээрээ өөрөөр хэлэх юм бол орон тоог нэмснээрээ сайжрах уу үгүй юу гэдэг дээр бас анхаарал тавиач. Хүний эрхийн хамгаалагчийн асуудал эрхэлсэн гишүүн оруулж ирэх хувилбар буюу хуулийн төслийн 10.2 дугаар заалт бол бас нөгөө орон тоог нэмснээр юу өөрчлөх юм бэ гэж би асуумаар байна. 6 гишүүнтэй болсноор санал тэнцвэл дарга эцсийн шийдвэр гаргамаар байна. Гэтэл Хүний эрхийн Үндэсний Комиссын хамтын шийдвэр гаргадаг институт одоо юм шүү дээ уг нь бол. Гэтэл энэ дээр санал зөрөх, санал тэнцэх энэ байдал үүсэж болзошгүй. Тэгэхээр энэ асуудлыг ер нь яаж зохицуулахаар оруулж ирж байгаа юм бэ гэдэг зүйлийг асуумаар байна.

Тэгээд комисс нь хүний бүхий л эрхээр хамтын шийдвэр гаргадаг бүтэц тул дагнасан гишүүн оруулж ирж байгаа энэ бүтцийг эвдэнэ гэж үзэж байгаа юм байна. Ер нь бол хүний эрхийн асуудлаар хүний эрхийн төлөө тэмцдэг төрийн бус

байгууллагууд иргэний нийгмийн байгууллагынхан бол маш олноор саналаа ирүүлж байна. Тэгэхээр энэ саналыг үндэслээд энэ үндэсний хороо гэдэг энэ асуудал анхаарвал яасан юм бэ гэдэг саналыг хэлэх гэсэн юм. Санал тэнцвэл яах вэ бүтцэд өөрчлөлт орохгүй юу гэдэг асуулт байна. Баярлалаа.

Г.Занданшатар: Дэмжсэн дэмжээгүй үг л хэлнэ. Зарчмын зөрүүтэй саналаар асуулт байхгүй. Хэлэлцэх эсэх дээр ингээд яригдсан асуудлууд байна. Ингээд санал хураалт явуулна. Санал хураалт. Санал хураалтад 63 гишүүн оролцож 55 гишүүн дэмжиж 55,6 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

17.Төслийн 11 дүгээр зүйлийн 11.1 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“11.1.Ашгийн төлөө бус хуулийн этгээдийн төлөөллөөс Хорооны гишүүнд дараах шаардлагыг хангасан хүнийг нэр дэвшүүлнэ:

11.1.1.хүний эрхийг хамгаалах чиглэлээр үндэсний, эсхүл олон улсын хэмжээнд долоогоос доошгүй жил ажилласан туршлагатай;

11.1.2.хүний эрхийг хамгаалах олон улсын тогтолцоо, эрх зүйн хэм, хэмжээний талаар мэдлэг, туршлагатай;

11.1.3.сүүлийн таван жил улс төрийн намын удирдах албан тушаал эрхэлж байгаагүй.” санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. Санал хураалтад 63 гишүүн оролцож 35 гишүүн дэмжиж 55,6 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

18.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 11 дүгээр зүйлийн 11.2 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулж, 11.2,11.3 дахь хэсэг болгох:

“11.2.Хорооны гишүүнийг ашгийн төлөө бус хуулийн этгээдийн төлөөллөөс дараах үе шатаар сонгоно:

11.2.1.Комисс нь хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, Комисс, Төрийн албаны зөвлөл, Жендэрийн үндэсний хороо, Комиссын дэргэдэх Иргэний нийгмийн зөвлөлийн төлөөллөөс бүрдсэн таван хүний бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг байгуулж, Хорооны гишүүнийг сонгон шалгаруулах ажлыг зохион байгуулах;

11.2.2.ажлын хэсэг Хорооны гишүүнд нэр дэвшигчийг сонгон шалгаруулах тухай зарыг хэвлэл мэдээллийн хэрэгслээр 30 хоногийн хугацаанд нийтэд мэдээлэх;

11.2.3.ажлын хэсэг энэ хуулийн 11.2.2-т заасан хугацаа дуусанаас хойш ажлын гурван өдрийн дотор сонгон шалгаруулалтад бүртгүүлсэн нэр дэвшигчийн хувь хүний нууцад хамаарахаас бусад мэдээллийг Комиссын цахим хуудаст байршуулах;

11.2.4.ажлын хэсэг энэ хуулийн 11.2.3-т заасан мэдээллийг байршуулснаас хойш 14 хоногийн дотор сонирхсон этгээд нэр дэвшигчээс асуух асуулт, саналыг хүлээн авах;

11.2.5.ажлын хэсэг энэ хуулийн 11.1-т заасан шаардлагыг хангасан нэр дэвшигчийн талаар нээлттэй сонсгол зохион байгуулах;

11.2.6.ажлын хэсэг нээлттэй сонсгол зохион байгуулснаас хойш ажлын 5 өдрийн дотор нууц санал хураалт явуулж, хамгийн өндөр оноо авсан нэр дэвшигчээс сул орон тоо гарсан гишүүний тоогоор Хорооны гишүүнээр сонгох.

11.3.Хорооны гишүүнийг сонгон шалгаруулах журмыг Комисс батална." санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. Санал хураалтад 63 гишүүн оролцож 38 гишүүн дэмжиж 60,3 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

19.Төслийн 11 дүгээр зүйлийн 11.3 дахь хэсгийн "Хүний эрхийн Үндэсний Комисс" гэснийг хасах санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 37 гишүүн дэмжиж 56,7 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

20.Төслийн 11 дүгээр зүйлийн 11.5 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

"11.5.Хорооны гишүүнийг гурван жилийн хугацаагаар зөвхөн нэг удаа сонгоно." санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 38 гишүүн дэмжиж 60,3 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

21.Төслийн 11 дүгээр зүйлийн 11.6.3 дахь заалтын "гэмт хэрэг үйлдсэн нь шүүхээр тогтоогдсон" гэснийг "гэм буруутайд тооцож эрүүгийн хариуцлага хүлээлгэсэн шүүхийн шийдвэр хуулийн хүчин төгөлдөр болсон." гэж, 11.7 дахь хэсгийн "Хороо боловсруулж, Хүний эрхийн Үндэсний Комиссоос баталж, мөрдүүлнэ" гэснийг "Комисс батална" гэж өөрчлөх санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 39 гишүүн дэмжиж 61,9 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

22.Ажлын хэсгийн гаргасан, Төсөлд доор дурдсан агуулгатай 12 дугаар зүйл нэмэх:

"12 дугаар зүйл.Хүний эрх хамгаалагчийн хорооны нэгж

12.1.Хорооны гишүүнд туслах чиг үүрэг бүхий орон тооны нэгж ажиллах бөгөөд бүтэц, орон тоог Комисс батална.

12.2.Хорооны нэгжийн ажилтан төрийн захиргааны албан хаагч байна.

12.3.Хорооны нэгж нь Комиссын Тамгын газарт харьяалагдах бөгөөд зөвхөн энэ хуулийн 10.2-т заасан чиг үүргийг хэрэгжүүлнэ." Санал гаргасан ажлын хэсэг. Дэмжсэн, дэмжээгүй 3 хүртэл гишүүн үг хэлж болно. 1 гишүүн үг хэлнэ. Төмөрбаатарын Аюурсайхан гишүүг үг хэлнэ. Аюурсайхан гишүүн.

Т.Аюурсайхан: Энэ 12 дугаар бас комиссын орон тоог тодорхой хэмжээгээр нэмэгдүүлж байгаа. Комисс энэ орон тоог нэмэгдүүлэх эрхийг эдэлж байгаа. Улсын Их Хурал дээрээс мэдээж төсвийг шийдэх асуудлыг ярина гэсэн үг. Тэгээд дахин захиж хэлэх зүйл бол энэ хуулиа батлуулаад үндэсний комисс бол ажлаа сайн хийгээрэй. Улсын Их Хурлаас ажиллах боломжийг чинь аль болохоор хангах талаар бүх чиглэлээр ажиллаа шүү. Хуулийг шинэчилж өглөө, та хэдийг ажилд чинь сонгон шалгаруулж томилж өглөө. Дахиад энэ эрх хамгаалагчийн хуулийг баталж хүн хүчийг чинь нэмж өгөх гэж байна. Ажиллах боломжийг чинь сайжруулж

өгөх гэж байна. Тэгээд үндэсний комиссын гишүүд бол нийгэмтэйгээ хамгийн ойрхон ажиллах ёстой хүмүүс шүү. Нийгэмтэйгээ ойрхон ажиллаарай. Зүгээр тусгаарлагдаад өндөр албан тушаалтан гээд одоо нийгмээсээ тусгаарлагдаад тийм дарга нар бол биш шүү. Хүндээ үйлчилдэг ийм байх ёстой. 24 цагаар ажиллуулдаг байнгын утасны шууд утасны сүлжээг ажиллуулах шаардлагатай гэж үзэж байгаа. Энэ чиглэлээр бодитой ажил хийх хэрэгтэй. Тэгэхгүй мэдээллээс их хол байна гэдэг хэлэлцүүлгийн үеэр хэлсэн шүү.

Одоо жишээлбэл 22 товчоо дээр нэвтэрч чадахгүй иргэн амь насаа алдахад мэдээгүй байсан. Хэвлэл мэдээллээс тодруулсан гэдэг юм байж болохгүй. Хүний эрх зөрчигдөж байгаа бүх асуудлууд дээр иргэд шууд Хүний эрхийн Үндэсний Комисс дээр холбогддог байх хэрэгтэй. 103 гээд түргэн тусламжийн дугаарыг мэддэг шиг Хүний эрхийн Үндэсний Комиссын дугаарыг хүн болгон мэддэг. Тийшээгээ ханддаг. Та бүхэн тэрийгээ ангилж ялгаж шуурхай асуудлыг нь зохих хүмүүст хүргэх ёстой газар дээр нь авах ёстой арга хэмжээг шуурхай авдаг. Цаг үеийн нийтлэг шинжтэй асуудлыг нийтлэг хэлбэрээр нь судалж шалтгаан нөхцөлийг нь тодорхойлж энэний дагуу ул суурьтай арга хэмжээ авахыг нь авдаг ийм байдлаар ажлын зарчмаа авч хэвшээрэй. Тэгээд Их Хурлаас бас олон гишүүд та бүхэнд бас урам өгч энэ ажил чинь саяхан томилоод удаагүй байгаа. Тийм учраас энэ илтгэлийг хариулах хэрэгтэй. Их олон хүмүүс харж байгаа. Иргэд алхам тутамд эрх нь зөрчигдөж байгаа шүү. Хүний эрхийн зөрчил маш их байгаа. Тэгээд энэ ахиц дэвшил бол байхгүй байгаа. Улам энэ гаараад улам хүний эрхийн зөрчил улам бүдүүлэг, харгис, хэрцгий хор уршиг үр дагавар нь улам хортой ийм нөхцөл байдалтай яваад л байгаа шүү. Тэгээд энэ дээр бодитой үнэлэлт дүгнэлт хийгээд энэ ажиллаарай. Тэгээд энэ заалтыг бол дэмжиж байгаа.

Г.Занданшатар: Үг хэллээ. Санал хураалт явуулна. Яах вэ энэ зүгээр дашрамд хэлэхэд Хүний эрхийн Үндэсний Комиссын илтгэлийг 3 сарын 31-ний дотор өргөн барих ёстой. Хүний эрхийн Үндэсний Комисс бол Улсын Их Хуралд зүгээр тайлан гаргаж өгдөг байгууллага биш. Шинэ шатанд гаргах ёстой энэ. Тэгээд 3 сарын 31-нээс өмнө Улсын Их Хурлын дэд дарга Аюурсайханд ажлын тайлан илтгэлээ танилцуулаад ажлынхаа явцыг танилцуулж үүрэг чиглэл авч ажиллана шүү. Их Хурлын дэд дарга Аюурсайхан энэ Хүний эрхийн Үндэсний Комиссыг хариуцаж ажиллана. Тайлангаа тавиарай. Санал хураалт. 34 гишүүн дэмжиж 54 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ. 12 дугаар зүйл.

23.Төслийн 12 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“12 дугаар зүйл.Хууль зөрчигчид хүлээлгэх хариуцлага

12.1.Энэ хуулийг зөрчсөн албан тушаалтны үйлдэл нь гэмт хэрэг, зөрчлийн шинжгүй бол Төрийн албаны тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

12.2.Энэ хуулийг зөрчсөн хүн, хуулийн этгээдэд Эрүүгийн хууль, эсхүл Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.” санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. Адьшаа гишүүн саналаа өгөөрэй. 40 гишүүн дэмжиж 63,5 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

24.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“13.1.Энэ хуулийг 2022 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.” санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. Энэ чинь яагаад ирэх оны 1 дүгээр сарын 01 болсон юм бэ? Төсөвтэй холбоотой хэсгийг нь л тэр заалтаа л 22 оны 01 сарын 01-нээс гээд бусад юмнууд чинь зохион байгуулах бэлтгэл ажил нь бүгд зогсоно шүү. Энийг эцсийн хэлэлцүүлэг дээрээ анхаараарай. Санал хураахгүй гүйцээн боловсруулах чиглэл өгч байна. Найруулгын санал.

1.Төслийн 2 дугаар зүйлийн 2.1 дэх хэсгийн “эдгээр” гэсний өмнө “болон” гэж, 11 дүгээр зүйлийн 11.6.1 дэх заалтын “захиргааны,”, “тусгай” гэсний өмнө “төрийн” гэж нэмэх.

2.Төслийн 6 дугаар зүйлийн 6.1.12 дахь заалтын “төрийн бус байгууллага, аж ахуйн нэгжийн” гэснийг “хуулийн этгээдийн” гэж, 6.1.13 дахь заалтын “ажиглалт хийх” гэснийг “ажиглагчаар оролцох” гэж, 7 дугаар зүйлийн 7.1.1 дэх заалтын “замаар” гэснийг “аргаар” гэж, 11 дүгээр зүйлийн 11.4 дэх хэсгийн “хүнийг” гэснийг “этгээдийг” гэж, “Хүний эрх хамгаалагчийг хамгаалах хорооны” гэснийг “Хорооны” гэж өөрчлөх.

3.Төслийн 11 дүгээр зүйлийн 11.4 дэх хэсгийн “Хүний эрхийн Үндэсний” гэснийг хасах.

4.Төслийн талаарх саналын томьёолол дэмжигдсэнтэй холбогдуулан нэр томьёог жигдлэх, зүйл, хэсэг, заалтын дугаарыг нийцүүлж өөрчлөх санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. Найруулгын санал. Санал хураалтад 37 гишүүн дэмжиж 58,7 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

Хүний эрхийн хамгаалагчийн эрх зүйн байдлын тухай хуулийн төслийн хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн талаар зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураая.

Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаарх саналын томьёолол: Хууль зүйн байнгын хорооны дэмжсэн санал:

1.Төслийн 1 дүгээр зүйлийн “хуульд” гэснийг “хуулийн 4 дүгээр зүйлд” гэж, “дараах хэсэг,” гэснийг “4.1.4 дэх” гэж өөрчлөх санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 38 гишүүн дэмжиж 60,3 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

2.Төслийн 2 дугаар зүйлийн “, 5.4 дэх” гэснийг хасах санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 38 гишүүн дэмжиж 60,3 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

3.Төслийн 3 дугаар зүйлийн “зүйлийн 21.2 дахь хэсэгт дараахь” гэснийг “зүйлд доор дурдсан агуулгатай 21.2.4 дэх” гэж, мөн зүйлийн 21.2.4 дэх заалтын “мөрдөн байцаагч” гэснийг “мөрдөгч” гэж өөрчлөх санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 41 гишүүн дэмжиж 65,1 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

Хоёр.Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаарх саналын томьёолол: Хууль зүйн байнгын хорооны дэмжсэн санал:

Төслийн 1 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“1 дүгээр зүйл.Зөрчлийн тухай хуулийн Тавдугаар бүлэгт доор дурдсан агуулгатай 5.20 дугаар зүйл нэмсүгэй:

“5.20 дугаар зүйл.Хүний эрх хамгаалагчийн эрх зүйн байдлын тухай хууль зөрчих

1.Хүний эрх хамгаалагчийг доромжлох, гүтгэх, үйл ажиллагааг нь дэмжихгүй байхыг уриалах, албадах арга хэрэглэсэн бол учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг нэг зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

2.Хүний эрх хамгаалагч нь хүчирхийллийн арга хэрэглэж, тайван бус аргаар үйл ажиллагаа явуулсан, явуулахыг уриалсан, хүний эрх хамгаалагчийн үйл ажиллагааг хувийн ашиг сонирхолд ашигласан, бусдын нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндийг гутаасан бол учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг нэг зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.”” 40 гишүүн дэмжиж 63,5 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ. Зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хурааж дууслаа. Хүний эрх хамгаалагчийн эрх зүйн байдлын тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Хууль зүйн байнгын хороонд шилжүүлж байна. Дараагийн асуудалд орно.